



Техникийн Туслалцааны Зөвлөхийн тайлан

Төслийн дугаар: 51387-001
2020 оны 10-р сар

Монгол улс: Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь

Монгол улс дахь КОВИД-19-ийн үеийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний үнэлгээ

Людовико Карраро, Ц.Амартүвшин
Оксфорд Полоси Менежмент
Оксфорд, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яаманд зориулав.

Зөвлөхүүдийн гаргасан энэхүү тайлан АХБ, Засгийн газрын байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг АХБ болон Засгийн газар хариуцахгүй болно.

Asian Development Bank

МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ХАРЬЦАА

(2020 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар)

Мөнгөн тэмдэгтийн нэгж	–	Төгрөг (MNT)
MNT1.00	=	\$0.00035
\$1.00	=	MNT2,841.47

ТОВЧЛОЛ

АХБ	–	Азийн Хөгжлийн банк
ААНОТ	–	Аж ахуйн нэгжийн орлогын татвар
ХМХ	–	Хүүхдийн Мөнгө хөтөлбөр
КОВИД -19	–	Коронавирус өвчин
ХЭБХ	–	Хүнсний эрхийн бичиг хөтөлбөр
ДНБ	–	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ӨНЭЗС	–	Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа
ӨМНС	–	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан
ХНХЯ	–	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
СЯ	–	Сангийн яам
ҮСХ	–	Үндэсний статистикийн хороо
ОПМ	–	Оксфорд полиси менежмент
ХХОАТ	–	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	–	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБХХ	–	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр
НҮБХС	–	НҮБ-ын Хүүхдийн сан
ДБ	–	Дэлхийн банк

Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь

АХБ ТТ 9893-МОН

Монгол улс дахь КОВИД-19-ийн үеийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний үнэлгээ

Людовико Карраро, Ц.Амартүвшин

2020 оны 10 дугаар сар



Оксфорд Полиси Менежментийн тухай

Оксфорд Полиси Менежмент (ОПМ) нь бага, дунд орлоготой улс орнуудад төрийн бодлогын шинэчлэл хийх замаар өсөлтийг бий болгож, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.

Бид бодлогын судалгаа, шинжилгээ, практик туршлагыг ашиглан тогтвортой эерэг өөрчлөлтийг бий болгохыг эрмэлзэн ажилладаг судалгааны байгууллага юм. ОПМ нь олон улс дахь сүлжээ байгууллагуудаараа улс орнуудын шийдвэр гаргагчидтай түншлэн, төрийн бодлогыг судлах, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх чиглэлээр ажилладаг.

ОПМ нь эрүүл мэнд, санхүү, боловсрол, цаг уурын өөрчлөлт, төсвийн байгууллагын менежмент зэрэг нийгэм, эдийн засгийн бодлого, засаглалын бүхий л салбарт ажиллаж, олон улсын болон үндэсний хэмжээнд мэргэшсэн зөвлөхүүдийн хамтаар, хамгийн сайн нотолгоонд суурилсан дэмжлэгийг үзүүлэхийн төлөө ажилладаг.

Өмнөх үг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хүсэлт гаргасны дагуу Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн Хүүхдийн Мөнгөний Хөтөлбөр болон Хүнсний эрхийн бичиг хөтөлбөрийн нэмэгдэл санхүүжилтийн үүрэг, ач холбогдлыг үнэлэх зорилгоор АХБ, НҮБ-ын Хүүхдийн сангаас дараах хоёр судалгааг явуулахаар зөвшилцсөн юм. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын бодлогууд нь төлөвлөсний дагуу хэрэгжсэн эсэх, түүний үр нөлөө, Засгийн газраас бодлого хэрэгжүүлээгүй тохиолдолд учрах эрсдэл, дээрх бодлогуудын ядуурал, тэгш бус байдалд үзүүлсэн нөлөөллийн талаарх шууд бус үнэлгээ
- Засгийн газраас авсан арга хэмжээ хэр сайн хэрэгжсэн, тэдгээрийн хэрэгцээ, бодлогын үр шимийг хүртэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох Засгийн Газрын дэмжлэгийг хүртэгчдийн судалгаа

Эхний судалгааг АХБ-ны төслийн (ТА 9883 – Нийгмийн хамгааллын үр дүнтэй системийг бий болгох нь) техникийн тусламжтайгаар, хоёр дахь судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр явуулж байна. Хоёр судалгаа бие биенээ дэмжих зорилготой бөгөөд хамтдаа Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын бодлогуудын үр нөлөөг цогцоор нь авч үзэн, үнэлэх боломжийг олгох юм.

Түүнчлэн, дээрх хоёр судалгаа нь хямралаас гарах шилжилтийн үеийн бодлогуудыг тодорхойлоход үнэ цэнэтэй мэдээлэл болно гэж итгэж байна.

Хураангуй

Оршил

Энэхүү тайланд Монгол улсын Засгийн газраас COVID-19 цар тахлаас шалтгаалсан хямралын нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын арга хэмжээний хамрах хүрээ, оновчтой байдалд хийсэн шууд бус үнэлгээний үр дүнг танилцуулна.

Үнэлгээ нь хамгийн сүүлд хийгдсэн өрхийн судалгаа (2018 оны Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа)-ны мэдээллийг ашиглан ядуурал, орлогын хуваарилалтын гурван өөр нөхцөлд хийсэн микро-симуляциас бүрдэнэ: суурь үе (Коронавируст халдварын цар тахал гарахаас өмнөх үе), цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн бууралтын нөлөөлөл, Засгийн газраас хямралд хариу арга хэмжээ болгож авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүн. Энэхүү дүн шинжилгээ нь Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хямралд өртсөн нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлгүүдийг бүрэн хамарч чадсан эсэх, тэдний амьжиргааг тодорхой түвшинд хамгаалахад хангалттай байсан эсэх талаар ойлголт өгөх зорилготой юм.

Монгол улс дахь COVID-19 цар тахлын эрүүл мэндийн шууд нөлөө одоогоор харьцангуй бага байгаа хэдий ч хэд хэдэн чанарын судалгааны үр дүнгээр хил хаах, худалдааны бууралт, сургууль болон бизнесийн зарим байгууллагуудыг хаасаны эдийн засгийн үр дагавар гарч байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын Засгийн газраас мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, хувь хүний орлогын албан татварыг бууруулах, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх болон ноолуурын үнийн уналтанд өртсөн малчдад дэмжлэг үзүүлэх болон бусад цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Арга зүй

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ хүн амын амьжиргааны түвшинд бодитоор хэрхэн нөлөөлсөн нь ирээдүйд хийгдэх үйл явдлын дараах үнэлгээгээр мэдэгдэнэ. Бидний хийж байгаа энэхүү (үйл явдлын өмнөх) үнэлгээ нь микро-симуляци ашиглан өөр өөр бодлогын хувилбаруудын орлогын хуваарилалт дахь болзошгүй үр нөлөөг тодорхойлох зорилготой.

1. COVID-ын өмнөх буюу суурь үеийн нөхцөл байдал: цар тахлын цочрол болоогүй байх үеийн ядуурал, тэгш бус байдлын нөхцөл байдал
2. COVID-19-ийн нөлөөлөл: Засгийн газраас бодлого хэрэгжүүлээгүй үеийн хямралын 'цэвэр' нөлөө
3. Хямралыг бууруулах Засгийн газрын хариу арга хэмжээ: Засгийн газрын бодлого нь хямралд өртсөн хүмүүсийн амьдралд хэр зэрэг хүрч, тэдний амьжиргааг хамгаалж байгаа эсэх

Гол төсөөлөл, таамаглал

Энэхүү дүн шинжилгээ нь хэдэн гол төсөөлөл дээр тулгуурлан өрхийн орлого, ядуурал болон тэгш бус байдалд үзүүлэх COVID-19-ийн нөлөөллийг үнэлсэн.

Суурь нөхцөл байдал

2018 оны ӨНЭЗС-ны мэдээллийг цочролын өмнөх нөхцлийг илэрхийлж чадах мэдээлэл гэж үзээд суурь үеийн нөхцөл байдал болгон ашигласан ба эдийн засгийн өсөлт хэвийн байх үеийн мэдээлэл гэж үзсэн. Дээрх судалгаа нь үндэсний ядуурлын түвшнээс гадна нийгэм, эдийн засгийн ялгаатай бүлгүүдийн орлого, ядуурлын түвшинг хамруулан ядуурлын үндсэн дүр төрхийг илэрхийлэх мэдээллээр хангах боломжтой.

КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хямрал

Коронавируст халдварын цар тахал худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлж, орлого ялангуяа, хөдөлмөр эрхлэлт (цалин, хөлстэй хөдөлмөр эрхлэлт болон хувиараа хөдөлмөр эрхлэлт)-ийн орлого буурахад нөлөөлсөн. Эдийн засгийн салбарын онцлогоос шалтгаалан хүлээгдэж буй үр нөлөө өөр өөр байх бөгөөд эдийн засгийн бууралтын талаарх таамаглалыг гаргахад салбаруудын тойм мэдээлэл хэрэгцээтэй юм.

Симуляци нь өрхийн түвшинд орлогын бууралтыг тооцоолохдоо өрхийн орлогын өөр өөр эх үүсвэрүүд түүнчлэн өрхийн гишүүн бүрийн ажил эрхлэлтийн орлогын эх үүсвэрийг харгалзан авч үзсэн.

Өрхийн хэрэглээний зардлыг мөн ижил хувиар буурсан гэж авч үзсэн. Энэ нь өрхүүд хадгаламжаа ашиглах эсвэл зээл авах зэргээр хэрэглээгээ хэвээр хадгалж үлдэх чадвар бага байгаа гэсэн үг.

Засгийн газрын КОВИД-19-ийн хариу арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газар КОВИД-19-ын хариу арга хэмжээ болгож санхүү, мөнгөний бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү судалгаанд бүх арга хэмжээг авч үзээгүй хэдий ч өрхийн орлоготой холбоотой дараах арга хэмжээнүүдийг илүү анхааран авч үзсэн. Үүнд:

- хувь хүнийг НДШ-ээс чөлөөлөх, ХХОАТ-аас чөлөөлөх (төрийн албан хаагчид хамаарахгүй)
- Хүүхдийн Мөнгөний Хөтөлбөр (ХМХ), Хүнсний Эрхийн Бичиг Хөтөлбөр (ХЭБХ) болон нийгмийн халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэх
- Ноолуурын үнийн татаас олгох

Үндсэн үр дүн

КОВИД-оос шалтгаалсан эдийн засгийн бууралтын төсөөлөлд тулгуурлан үзвэл цар тахал өрхийн орлогыг дунджаар 10%-иар бууруулахаар байсан гэж тооцоолсон. Энэ нь ҮСХ-ны мэдээлсэн нэг болон хоёрдугаар улирлын ДНБ-ий бууралттай ойролцоо байна. Зарим хүмүүсийн орлого мэдэгдэхүйц буурч, зарим нь өөрчлөгдөөгүй эсвэл зарим нь нэмэгдсэн байдаг тул энэ дундаж нь өөрчлөлтийн тоймыг харуулж байна. Энэ нь 4 сараас 9 сард нийгмийн хамгааллын голлох хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлээгүй гэж үзсэн үеийн нөхцөл байдлыг илэрхийлнэ.

Засгийн газрын бодлогын арга хэмжээний нөлөөллийг авч үзэхэд энэхүү бодлого нь цар тахлын сөрөг нөлөөг арилгаж хүмүүсийн орлогыг суурь үеийн орлоготой харьцуулахад дунджаар 16%-иар нэмэгдүүлсэн байна. Гэсэн ч зарим хүмүүсийн орлого буурсан ч нөгөө хэсгийнх нь орлого улам их нэмэгдсэн тохиолдол байна.

Бидний хийсэн дүн шинжилгээ Засгийн газраас цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй бол тэгш бус байдал, ядуурлын аль аль нь мэдэгдэхүйц нэмэгдэж, харин цогц арга хэмжээ авч хэрэгжүүлснээр ядуурлыг суурь үеийнхээс ч бууруулж чадахаар байгааг харуулж байна.

Харин ХМХ-ийн төсвийн 26.4% нь хүн амын ядуу 20%-д очиж байхад ердөө 13.2% нь чинээлэг 20%-д очиж байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр орлого дахин хуваарилалтын бодлого болж чадсан. НДШ-ийн чөлөөлөлт хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд (хувиараа нийгмийн даатгал төлдөг) бага зэрэг нөлөөтэй ба малчдад үзүүлж буй дэмжлэг төдийлөн нөлөөгүй байна.

Нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлгүүдэд үзүүлж байгаа нөлөөлөл болон 3 өөр нөхцөл байдал дахь ядуучуудын хувийг өрхийн төрлөөр харьцуулан үнэлгээ хийсэн. **Үнэлгээгээр суурь үетэй харьцуулахад хүүхэдтэй бүх өрхүүд ядууралд өртөх нь мэдэгдэхүйц буурсан.** Гэхдээ хүүхэдгүй хосууд, нэг хүнтэй өрх болон бүх гишүүд нь насанд хүрэгчдээс бүрдсэн өрхийн ядуурал нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэний дараа ч нэмэгдсэн эвсэл хэвэндээ байна. Гэхдээ тийм өрхүүдийн ядуурлын түвшин хүүхэдтэй өрхүүдээс хамаагүй бага байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын хувилбарууд

Хэдийгээр зарим салбарт цар тахал сөргөөр нөлөөлсөн хэвээр байгаа ч статистикийн 8, 9 дүгээр сарын мэдээгээр эдийн засаг сэргэж байгаа эерэг үр дүн харагдаж байна. Энэ бүхэн нь өрхүүдийг дэмжих замаар үзүүлж байгаа одоогийн тусламж нь хожим хэцүү цаг үе тохиолдоход төсөвт хүндрэл учруулахгүйгээр хяналттай зарцуулахад чиглэсэн, илүү оновчтой стратегийг Засгийн Газраас хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Нэмэгдүүлсэн хүүхдийн мөнгийг өрхийн мэдээллийн нэгдсэн санг ашиглан бага хэмжээний шилжүүлэгтэй хослуулан харьцангуй ядуу өрхүүдэд олгох боломжтой. Цар тахал болон эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт нь мэдээллийн баазын зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох байдалд нөлөөлсөн байж болзошгүй хэдий ч тархалтын доод хэсэгт байгаа өрхүүдэд нөөцийг илүү оновчтой хуваарилах хэрэгсэл хэвээр байх болно.

Түүнчлэн ийм шилжүүлгийг цар тахлын нөлөөнд өртсөн, цаашид ч энэ байдал нь үргэлжлэх магадлалтай салбарт ажиллагчдыг дэмжих хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлоготой хослуулж болно.

Дүгнэлт, зөвлөмж

Энэхүү судалгааны үр дүн нь эдийн засгийн бууралтын хүнд нөхцөл байдал, ажлын байраа алдсан хүмүүсийн эзлэх хувь гэсэн таамаглалаас ихээхэн хамаарах хэдий ч Засгийн газраас авч хэрэгжүүлсэн ХМХ, ХЭБХ болон ялангуяа, нийгмийн халамжийн тэтгэвэрийг нэмэгдүүлэх хариу арга хэмжээ нь ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад чиглэж, ихээхэн үр дүнтэй хэрэгжсэн гэдгийг харуулж байна. 2020 оны 4 дүгээр улиралд НДШ-ийн чөлөөлөлтийн хувийг бууруулж, ХХОАТ-ыг эргэн сэргээж, ХМХ-ийг үргэлжлүүлэх нь тохиромжтой арга хэмжээ гэж үзэж байна.

Одоогийн тулгамдаж байгаа сорилт нь 2021 оны бодлогын хувилбаруудыг тодорхойлох явдал юм. Хэрвээ ХМХ-ийн нэмэгдлийг буурууллаа гэхэд анх олгож эхэлсэн тэтгэмжийн бодит өртөгтэй ойролцоо байлгахын тулд 40,000 төгрөгөөс доош оруулахгүй байх хэрэгтэй. Түүнчлэн, цар тахлаас шалтгаалан эдийн засгийн хүндрэлд өртөж байгаа салбаруудад туслахын тулд өрхийн мэдээллийн нэгдсэн санг ашиглан харьцангуй ядуучуудад зориулсан тэтгэмжийг бий болгох, ямар бодлого хэрэгжүүлэхийг тодорхойлох боломжтой.

Агуулга

ӨМНӨХ ҮГ	II
ХУРААНГУЙ	III
Оршил	III
Арга зүй.....	III
Гол төсөөлөл, таамаглал	III
Үндсэн үр дүн.....	IV
Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын хувилбарууд.....	VI
Дүгнэлт, зөвлөмж	VI
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	VIII
1 ОРШИЛ, ТАНИЛЦУУЛГА	9
1.1 Үнэлгээний зорилго	9
1.2 ЦАР ТАХЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ	9
1.3 Одоогоор хийгдсэн болон цаашид хийгдэх судалгааны ажлууд	10
1.4 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ.....	11
2 ЭДИЙН ЗАСГИЙН ЦОЧРОЛЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ, ТААМАГЛАЛ	12
2.1 Суурь үе	12
2.2 КОВИД-19 ЦАР ТАХЛААС ШАЛТГААЛСАН ХЯМРАЛ.....	12
3 ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ	19
3.1 Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлт	20
4 ҮР ДҮН	24
5 БОДЛОГЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУВИЛБАРУУД	30
6 ДҮГНЭЛТ, ДАРААГИЙН АЛХАМ	33
НОМ ЗҮЙ	34
Хавсралт А: Статистикийн нарийвчилсан хэмжүүрүүд	35

Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1: Ажиллагчдын тоо, салбарын ангиллаар	15
Хүснэгт 2: Эдийн засгийн бууралт, их, дунд, бага хэмжээгээр, салбараар	16
Хүснэгт 3: Эдийн засгийн бууралтын хувилбар тооцоолол (2020 оны 4-9 сар)	18
Хүснэгт 4: ӨНЭЗС дахь бодлогын арга хэмжээнд хамрагдалт, төсөв (2020 оны 4-9 сар)	22
Хүснэгт 5: ӨНЭЗС дахь бодлогын арга хэмжээнд хамрагдалт, төсөв (2020 оны 10-12 сар)	23
Хүснэгт 6: Суурь үетэй харьцуулсан 2020 оны орлогын дундаж, тархалтын өөрчлөлт..	24
Хүснэгт 7: Ядуурал болон тэгш бус байдлын хэмжүүр – 2020 оны 4-9 сар	25
Хүснэгт 8: 4-9 сарын төсвийн тархалт, хүн амын тооны таван тэнцүү бүлгээр, бодлогын төрлөөр	27
Хүснэгт 9: Ядуурал болон тэгш бус байдлын хэмжүүр – 2020 оны 4-р улирал.....	29
Хүснэгт 10: ХМХ, ХЭБ хөтөлбөрийн үр шимийг хүртэгчдийн тархалт, цар тахлын өмнө болон дараах өөр хүн амын хамралтыг авч үзсэн	31
Хүснэгт 11: Өөр өөр шаардлагыг хангасан иргэдэд олгох боломжит шилжүүлгийн төсвийн тархалт, эдийн засгийн хямралтай 2020 оны 4-9 сарыг хамруулан симуляци хийсний дагуу.....	31
Хүснэгт 12: Тэгш бус байдал, ядууралд өөр өөр шилжүүлгийн хувилбаруудын нөлөө, эдийн засгийн хямралтай үед зарцуулах төсөв 2020 оны 4-9 сарыг хамруулан симуляци хийсний дагуу.....	32
Хүснэгт 13: Тэгш бус байдал, ядууралд өөр өөр шилжүүлгийн хувилбаруудын нөлөө, эдийн засгийн хямралтай үед зарцуулах төсөв 2020 оны 10-12 сарыг хамруулан симуляци хийсний дагуу.....	32
Хүснэгт 14: Ядуурлын дүр төрх, хувилбар тооцоо – 2020 оны 4-9 сар	37
Хүснэгт 15: Ядуурлын дүр төрх, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдэл, НДШ/ХХОАТ-ын чөлөөлөлттэй үед – 2020 оны 4-9 сар	38
Зураг 1: Орлогын эх үүсвэр, газар зүйн бүсээр, ядуурлын түвшингээр,%, 2018 он	14
Зураг 2: Өсөн нэмэгдэх тархалтын функц - 2020 оны 4-9 сар	26
Зураг 3: Өөр өөр хувилбараар тооцсон ядуу хүн амын эзлэх хувь - 2020 оны 4-9 сар ..	27
Зураг 4: 2020 оны 4-9 сар – Суурь үетэй харьцуулсан нэг хүнд ногдох хэрэглээний зардлын өөрчлөлтийн хувь (цочролын дараах хэрэглээгээр эрэмбэлсэн)	28
Зураг 5: Ядуу хүн амын хувь, ерхийн төрлөөр, гурван өөр хувилбараар: суурь үе, КОВИД-19 ба нийгмийн хамгааллын арга хэмжээ - 2020 оны 4-9 сар	29
Зураг 6: Цочролын өмнө болон дараах үеийн хэрэглээний өөрчлөлт– 2020 оны 4-9 сар	35
Зураг 7: Цочролын өмнө болон дараах үеийн хэрэглээний өөрчлөлт – sentile тус бүрийн дундаж – 2020 оны 4-9 сар.....	36
Зураг 8: Суурь үетэй харьцуулсан нэг хүнд ногдох хэрэглээний зардлын өөрчлөлтийн хувь (цочролын дараах хэрэглээгээр эрэмбэлсэн) –2020 оны 4-9 сар	36

1 Оршил, танилцуулга

1.1 Үнэлгээний зорилго

1. Энэхүү тайланд КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хямралын нөлөөллийг буруулахаар Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын арга хэмжээний хамрах хүрээ, оновчтой байдалд хийсэн шууд бус үнэлгээний үр дүнг танилцуулна.

2. Үнэлгээ нь хамгийн сүүлд хийгдсэн өрхийн судалгаа (2018 оны Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа)-ны мэдээллийг ашиглан ядуурал, орлогын хуваарилалтын гурван өөр нөхцөлд хийсэн микро-симуляциас бүрдэнэ. Үүнд:

- суурь үе (Коронавируст халдварын цар тахал гарахаас өмнөх үе)
- цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн бууралтын нөлөөлөл
- Засгийн газраас хямралд хариу арга хэмжээ болгож авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүн

3. Энэхүү дүн шинжилгээ нь Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ хямралд өртсөн нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлгүүдийг бүрэн хамарч чадсан эсэх, тэдний амьжиргааг тодорхой түвшинд хамгаалахад хангалттай байсан эсэх талаар ойлголт өгөх зорилготой юм.

4. Энэхүү дүн шинжилгээний үр дүнг танилцуулахаас өмнө цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын тодорхой арга хэмжээнүүд болон Монгол улс дахь цар тахлын нөлөөллийг тодорхойлохын тулд хийгдсэн судалгаануудыг авч үзэх нь чухал юм.

1.2 Цар тахлын эдийн засгийн нөлөөлөл

5. Монгол улс дахь КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн шууд нөлөө одоогоор харьцангуй бага байгаа хэдий ч хэд хэдэн чанарын судалгааны үр дүнгээр хил хаах, худалдааны бууралт, сургууль болон бизнесийн байгууллагуудыг хаасаны эдийн засгийн үр дагавар гарч байгаа нь харагдаж байна.

6. АХБ-ны тооцоолсоноор 2020 онд Монгол улсын эдийн засагт огцом уналт ажиглагдаж болзошгүй. Түүнчлэн, ҮСХ-ноос гаргасан мэдээгээр 2010 оны үнээр үнэлсэн ДНБ-ий өсөлт 2020 оны 1 дүгээр улиралд 2019 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 10.7 хувиар буурсан байна. Энэхүү бууралт нь уул уурхайгаас гадна тээвэр, үйлчилгээ болон боловсруулах аж үйлдвэрийн салбарын бууралтаас голлон шалтгаалжээ. Хөдөө аж ахуйн салбар нь эерэг нөлөө ганц үзүүлэх салбар болж байна. Нийлүүлэлтийн талд, өрхийн хэрэглээ өсч байхад хөрөнгө оруулалт, цэвэр экспорт нь буурсан.

7. ҮСХ болон Дэлхийн банкнаас¹ хамтран гаргасан тайланд дурдсанаар үндэсний ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувьтай байснаас гадна нийт хүн амын 15 хувь нь үндэсний ядуурлын шугам (ядуурлын шугамын 1.25 дотор)-ын ердөө дээд талд нь төвлөрсөн байдалтай дүр зураг гарсан. Гэнэтийн цочрол гарсан тохиолдолд дээрх хүн ам нь ядууралд өртөх эрсдэлтэй бөгөөд коронавируст халдварын цар тахал нь ийм цочролын нэг юм. Ийм хүнд хэцүү сорилт дээрх нөхцөл байдалд тохиолдож байна.

¹ Uochi, I. (2020): Mongolia Poverty Update 2018 (English). Washington D.C.: World Bank Group. <http://documents.worldbank.org/curated/en/532121589213323583/Mongolia-Poverty-Update-2018>.

1.3 Одоогоор хийгдсэн болон цаашид хийгдэх судалгааны ажлууд

8. Бидний мэдэж байгаагаар КОВИД-19 цар тахлын нөлөөллийн талаар дараах судалгаа, түргэвчилсэн үнэлгээний ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- **НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн газраас Монгол улсын эмзэг бүлэгт үзүүлэх КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг тодорхойлох үнэлгээ.** Уг үнэлгээний зорилго нь олон нийтийг өөрсдийн нөөц, боломжоо ашиглан хэвийн амьдралдаа шилжихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас цар тахлын нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа зорилтот бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг цуглуулах явдал юм. Ярилцлагыг өрхийн түвшинд, малчид, жижиг бизнес эрхлэгчид, орон нутгийн удирдлагуудтай хийж байгаагаас гадна цар тахлаас шалтгаалсан хямрал амьжиргаанд нь хамгийн их нөлөөлсөн эмэгтэйчүүд, залуучуудад онцгой анхаарал хандуулж байгаа юм. Үнэлгээг Монгол Улсын Засгийн газар, түүний дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Сангийн яам (СЯ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Монголбанк болон НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын ХХААБ, ОУХБ, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага зэрэг НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран явуулсан байна.
- **Дэлхийн банк, Үндэсний статистикийн хорооны КОВИД-19 цар тахлын өрхөд үзүүлж буй нөлөөг “цаг тухайд нь хянах”² судалгаа.** Энэхүү судалгааны зорилго нь (i) иргэдийн амьжиргаанд хямрал хэр зэрэг нөлөөлж байгааг судлах, цар тахлын нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд зориулсан өрхийн түвшний мэдээллийг утсаар цуглуулах;
(ii) Ирээдүйд болзошгүй хямралын тохиолдолд түргэн хугацаанд судалгааг төлөвлөх, зохион байгуулж явуулах, үр дүнг нэгтгэн гаргах чиглэлээр ҮСХ-ны чадавхийг бэхжүүлэх явдал юм.
Энэхүү утсанд суурилсан судалгааны эхний шатыг 5, 6 дугаар сард явуулсан бөгөөд дараагийн шатыг 8 дугаар сарын сүүлч болон 9 дүгээр сард явуулахаар төлөвлөж байна.
- ҮСХ-ны **“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус (COVID-19)-ээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөлөл”³.** ҮСХ-ноос энэхүү судалгааг “Covid-19” халдварт өвчний эсрэг авч буй урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон өрх, хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж, ямар өөрчлөлт гарч байгааг таандах зорилгоор 2020 оны 4-р сарын 1-нээс 5-р сарын 20-ны өдрүүдэд нээлттэй байдлаар буюу онлайнаар зохион байгуулсан.

9. Дээрх судалгааны ажлууд нь өрхийн орлогод хямрал хэрхэн нөлөөлж байгаа талаарх таамаглалыг боловсруулах үндэслэл болно.

10. Дээрх судалгаануудаас гадна Монгол дахь **НҮБ-ын Хүүхдийн сангийн** дэмжлэгтэйгээр КОВИД-ын хариу үйлдэл болгож Хүүхдийн мөнгөний хөтөлбөр (ХМХ) болон Хүнсний эрхийн бичиг хөтөлбөрийг (ХЭБХ) өргөжүүлэх талаарх түргэвчилсэн үнэлгээг хийж байна. Энэ судалгаа нь бидний хийсэн үнэлгээг нийгмийн хамгааллын голлох бодлогын арга хэмжээний хэрэгжилт, нэмэлт санхүүжилтийн ашиглалт, сэтгэл

² <https://www.worldbank.org/en/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia> харна уу.

³ [https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Impact of COVID-19 on Business Activities.pdf&ln=En](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Impact%20of%20COVID-19%20on%20Business%20Activities.pdf&ln=En) харна уу.

ханамж, иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа талаарх нэмэлт мэдээллээр баяжуулах юм.

1.4 Тайлангийн бүтэц

11. Энэхүү үнэлгээний тайлан дараах хэсгүүдээс бүрдэнэ. Дараагийн бүлэгт, бэлэн байгаа мэдээллийг ашиглан короновируст халдварын цар тахал нь эдийн засгийн үйл ажиллагаа, иргэдийн орлогод хэрхэн нөлөөлсөн талаарх төсөөлөл, таамаглалыг хэрхэн гаргасан талаар оруулсан. Мөн уг таамаглал дээр үндэслэн судалгааны мэдээллийн баазыг ашиглан хэрхэн симуляци тооцоо хийх тухай тайлбарласан. Гурав дахь хэсэгт Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч үзэн, тэдгээрийг судалгааны мэдээллийн баазад, тооцоололд хэрхэн тусгасан талаар тайлбарлана. Дөрөв дэх хэсэгт үндэсний ядуурлын түвшин болон нийгэм-эдийн засгийн ялгаатай бүлгүүдийн тэгш бус байдалд нөлөөлөх нөлөөллийг танилцуулна. Төгсгөлд нь урьдчилсан дүгнэлт болон цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай алхмуудыг танилцуулна.

2 Эдийн засгийн цочролын талаарх төсөөлөл, таамаглал

2.1 Суурь үе

12. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгаа нь хэдийгээр хамгийн сүүлд хийгдсэн судалгаа боловч коронавирусын цар тахлаас өмнө буюу 2018 оноос 2020 оны эхэн үе хүртэл томоохон өөрчлөлт гарсан эсэхийг тодорхойлох нь чухал юм. Энэ нь үндсэндээ эдийн засгийн өсөлт, эдийн засгийн тодорхой салбаруудын гүйцэтгэл, инфляцаас хамаарч эдийн засагт ямар нэгэн дорвитой зүйл тохиолдсон эсэхийг харгалзан авч үзэж байгаа юм.

13. Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2018, 2019 онуудад 10 хувиар өссөн боловч бодит өсөлт харьцангуй бага буюу 1.8 хувь байсан. Хэрэглээний үнийн индекс 2019 онд өмнөх оноос дунджаар 7.2 хувиар өссөн байна. Эдийн засгийн зарим салбаруудад, ялангуяа жилийн зарим улиралд бусад салбаруудаас илүү сайн гүйцэтгэлтэй байсан бол дээрх ялгаа их биш байх юм.

14. Монгол улсад ажиглагдсан ядуурлын мэдрэмжийн тооцооллын бага өсөлт болон өөрчлөлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр (ЮОчи 2020, 25-р хуудсыг харна уу) өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны тоо мэдээлэл нь цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн цочролын өмнөх нөхцөл байдлыг боломжийн илэрхийлж байна гэж бид үзэж байна.

15. Дээрх судалгаа нь үндэсний ядуурлын түвшингээс гадна нийгэм, эдийн засгийн ялгаатай бүлгүүдийн орлого, ядуурлын түвшинг хамруулан ядуурлын үндсэн дүр төрхийг илэрхийлэх мэдээллээр хангана.

2.2 КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хямрал

16. Коронавируст халдварын цар тахал худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлж, орлого ялангуяа, хөдөлмөр эрхлэлт (цалин хөлстэй хөдөлмөр эрхлэлт болон хувиараа хөдөлмөр эрхлэлт)-ийн орлого буурахад нөлөөлсөн. Эдийн засгийн салбарын онцлогоос шалтгаалан хүлээгдэж буй үр нөлөө өөр өөр байх бөгөөд эдийн засгийн бууралтын талаарх таамаглалыг гаргахад салбаруудын тойм мэдээлэл хэрэгцээтэй юм.

17. Микро-симуляцид ашигласан үндсэн арга нь хэсэгчилсэн тэнцвэр ба эдийн засгийн уналтын гэнэтийн нөлөөг бид харгалзан авч үзсэн. Гэхдээ энэ нь цочролыг өдөөж байгаа өөрчлөлт (ажлаа өөрчлөх зэрэг)-д нөлөөлөх хүчин зүйл биш юм. Энэ нь цочролын богино хугацааны нөлөөг тодорхойлоход боломжийн сайн сонголт гэдгийг харуулж байна.

18. Түүнээс гадна өрхийн түвшний орлогын бууралтыг симуляци хийсний дараа хэрэглээний зардал ижил хувиар буурна гэж үзсэн. Энэ нь өрхүүд хадгаламжаа зарцуулах болон зээл авах замаар хэрэглээгээ төлөх чадвар маш бага гэж таамаглаж байгаатай холбоотой. Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгааны эхний шатны үр дүнгээс харахад цөөн өрх (7 орчим хувь) хадгаламжаа ашигласан, нэлээд өрх найз нөхөд, биенесийн байгууллагаас зээл авсан бол бусад нь хэрэглээгээ багасгасан байна. Ерөнхийдөө өрхийнхөө хүнсний аюулгүй байдал болон санхүүд санаа их зовж байгаагаар илэрхийлжээ. Тиймээс энэ таамаглал нь ялангуяа тархалтын доод хэсгийн өрхүүдийн хувьд тийм ч бодитой бус юм.

19. Орлогын бууралтыг загварчлахдаа өрхийн орлогын ялгаатай эх үүсвэрүүдийг болон өрхийн гишүүн бүрийн ажил эрхлэлтийн орлогын эх үүсвэрийг харгалзан авч үзсэн.


20. Орлогыг дараах таамаглалын дагуу загварчилсан:

- Ажиллаж байгаа салбараасаа хамааран иргэдийн орлого буурна;
- Гадаад мөнгөн гуйвуулгын орлого 20 хувиар буурна (дэлхийн түвшинд гадаад гуйвуулга буурах ерөнхий таамаглалд үндэслэсэн⁴);
- Дотоод мөнгөн гуйвуулга 10 хувиар буурна (хүлээгдэж буй дундаж бууралт);
- Тэтгэвэр, нийгмийн хамгааллын бусад шилжүүлгүүд болон хөрөнгийн орлого нөлөө үзүүлэхгүй.

21. Монгол улсын өрхийн орлогын эх үүсвэрийг газар зүйн бүс нутгаар, орлогын түвшингээр, суурь түвшинд Зураг 1-р харуулж байна. Бүлгүүдийн хувьд авч үзвэл иргэдийн нийт орлогын 70 орчим хувийг хөдөлмөр эрхлэлтийн орлого (цалин хөлс, бизнесийн орлого, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого) эзэлж байгаа бөгөөд орлогын бүтэц газар зүйн бүсийн хувьд хот, хөдөөгийн орлогын эх үүсвэр ихээхэн ялгаатай байна. Улаанбаатар хот болон аймгийн төвд цалинтай ажиллагчдын орлого голчилж байгаа бол хөдөө орон нутагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого хамгийн том орлогын эх үүсвэр болж байна. Ядуу өрх болон бусад өрхийн хөдөлмөрийн бус орлогыг харьцуулан үзвэл хөдөлмөрийн бус орлогын бүрэлдэхүүн хэсэг ихээхэн ялгаатай байна. Ядуу хүн амын нийт орлогын 12 орчим хувийг нийгмийн халамж тусламж эзэлдэг бол энэ үзүүлэлт нийт өрхийн хувьд ердөө 4 хувийг эзэлж байна. Харин эсрэгээрээ ядуу бус болон харьцангуй чинээлэг өрхийн хувьд хувийн шилжүүлгийн орлого нь орлогын чухал эх үүсвэр юм. Ядуучуудын нийт орлогын 12 хувийг нийгмийн халамж бүрдүүлж байхад ядуу бусчуудын орлогын ердөө 3 хувийг бүрдүүлж байна. Харин ядуу бус өрхүүд болон харьцангуй боломжийн өрхүүдийн хувьд хувийн шилжүүлэг орлогын томоохон эх үүсвэр болж байна.

⁴ <https://www.worldbank.org/en/news/press-release/2020/04/22/world-bank-predicts-sharpest-decline-of-remittances-in-recent-history> харна уу.

Зураг 1: Орлогын эх үүсвэр, газар зүйн бүсээр, ядуурлын түвшингээр, %, 2018 он



Эх үүсвэр: ӨНЭЗС – 2018 -д үндэслэсэн тооцоолол. Ядуу, ядуу бусыг албан ёсны ядуурлын шугамд үндэслэн тодорхойлсон. (ядуу = хүн амын 28.4%).

22. Коронавируст халдварын цар тахлын улмаас өрхийн орлогод үзүүлэх эдийн засгийн үр нөлөөг тодорхойлоход хөдөлмөр эрхлэлтийн орлого хэрхэн нөлөөлснийг үнэлэх нь маш чухал юм. Түүнчлэн цар тахлын өрхийн орлогод үзүүлэх эдийн засгийн нөлөөллийг тодорхойлоход хөдөлмөр эрхлэлтийн орлого хэрхэн нөлөөлснийг үнэлэх нь нэн чухал юм. Үүнээс гадна, эдийн засгийн янз бүрийн салбаруудын ач холбогдлыг ойлгох хэрэгтэй.

23. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны мэдээлэлд үндэслэн тооцсон ажиллагчид (цалин, хөлстэй ажиллагч эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэгч эсэхээс үл хамааран)-ын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар хүснэгт 1-д харуулав. Хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, боловсрол, аялал жуулчлал зэрэг үндсэн салбаруудад нийт 1.22 сая⁵ хүн хөдөлмөр эрхэлж байна. Цалин, хөлстэй ажиллагч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо салбаруудаар ихээхэн ялгаатай байна. Цалин, хөлстэй ажиллагчид боловсрол, бөөний, жижиглэн худалдаа, төрийн удирдлага, барилга, аялал жуулчлал, аж үйлдвэр, уул уурхай зэрэг салбаруудад голчлон хөдөлмөр эрхэлдэг бол хувиараа хөдөлмөр эрхлэгчид хөдөө аж ахуй, бөөний жижиглэн худалдаа, аялал жуулчлалын салбарт ажлын байраар хангагдаж байна⁶.

⁵ Энэ нь ҮСХ-ноос 2018 онд гаргасан тоо мэдээлэл /1.25 сая/-тэй их ойролцоо байна. (https://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0400_010V1)

⁶ Аялал жуулчлалын үйл ажиллагааг ихэвчлэн тусад нь салбараар тооцон гаргадаггүй тул бид ӨНЭЗС-ын мэдээллээс кодыг ашиглан тооцож гаргасаныг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Ялангуяа энэ салбар хямралд нэрвэгдсэн байх магадлалтай салбар юм. Аялал жуулчлалын салбарын ажиллагчид үндсэндээ эдийн засгийн дараах салбаруудаас бүрддэг. Үүнд байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, тээврийн салбарын сонгогдсон зарим үйл ажиллагаа, тээврийн нэмэлт үйлчилгээ, аялал жуулчлалын агентлагийн үйл ажиллагаа, урлаг, үзвэр, спорт үйл ажиллагаа.

Хүснэгт 1: Ажиллагчдын тоо, салбарын ангиллаар

Салбар	Цалинтай ажиллагч	Хувь иараа хөдөлмөр эрхлэгч	Нийт
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	20497	272750	293246
Уул уурхай, олборлолт	64311	6374	70685
Боловсруулах үйлдвэрлэл	70601	21959	92560
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16243	53	16295
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5741	1020	6761
Барилга	79053	11577	90631
Бөөний болон жижиглэн худалдаа	97966	67147	165114
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	17223	7566	24790
Мэдээлэл, холбоо	15591	603	16194
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	25276	714	25990
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1166	0	1166
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12330	1469	13800
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	17608	1346	18954
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	87528	68	87596
Боловсрол	111503	988	112491
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	47396	903	48300
Урлаг, үзвэр, тоглоом наадам	793	0	793
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	14493	7640	22133
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	1665	1273	2939
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1240	57	1297
Аялал жуулчлал	77457	31720	109177
Нийт	785682	435227	1220909

Эх үүсвэр: ӨНЭЗС – 2018 -д үндэслэсэн тооцоолол.

24. Коронавирусийн нөлөөллийг тодорхойлсон судалгаа (ҮСХ-ноос Дэлхийн банкны дэмжлэг, тусламжтайгаар хийсэн судалгаа. Мэдээллийг өрх, аж ахуйн нэгжээс утсаар болон онлайнаар цуглуулсан), НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас хийсэн шинжилгээ зэрэг эдийн засгийн салбаруудад коронавирус цар тахлын үзүүлсэн нөлөөний талаар мэдээлэл бидэнд байна. Эдгээр үнэлгээ нь Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө хийгдсэн тул хариу арга хэмжээний өмнөх үеийн коронавирусн цар тахал /Ковид-19/-ын эдийн засгийн нөлөөллийг дүрслэн харуулсан болно.

25. ҮСХ-ноос явуулсан судалгаагаар⁷ цар тахлын улмаас аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарч байгаа эсэхийг асуусан. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэвийн бус гэж хариулсан хувь салбар бүрийн хувьд өөр өөр байна. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэвийн бус явагдаж байна гэж хариулсан салбарын хувь 65 ба түүнээс дээш хувь бол их хэмжээ, үйл ажиллагаа хэвийн бус явагдаж байна гэж хариулсан салбарын хувь 35-65 хувь бол дунд хэмжээ, хэвийн бус гэж хариулсан салбарын хувь 35 ба түүнээс доош бол бага хэмжээтэй бууралт гэж ангилж үзсэн.

Хүснэгт 2: Эдийн засгийн бууралт, их, дунд, бага хэмжээгээр, салбараар

Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ; Боловсрол (үйл ажиллагааны тасалдлыг орлогын бууралт гэж орчуулах шаардлагагүй); Аялал жуулчлал; Урлаг, үзвэр, тоглоом наадам	Их
Бөөний болон жижиглэн худалдаа Боловсруулах аж үйлдвэр Барилга Хөдөө аж ахуй, ойн аж ахуй Үйлчилгээний бусад үйл ажиллагаа Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа Уул уурхай, олборлолт Мэдээлэл, холбоо Цахилгаан, хий	Дунд
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа Усан хангамж, бохир ус зайлуулах систем	бага

Эх үүсвэр: ҮСХ-ны аж ахуйн нэгжийн судалгаанд үндэслэсэн тооцоолол:

https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Impact_of_COVID-19_on_Business_Activities.pdf&In=En.

26. Эдийн засгийн алдагдлын цар хүрээний хувьд бидэнд зөвхөн салбаруудын нэгтгэсэн түвшний мэдээлэл байгаа бөгөөд энэ нь аж ахуйн нэгжүүдийн хариулсан мэдээлэл юм. Ерөнхийдөө аж ахуйн нэгжийн алдагдал дунджаар 40 хувь байгаа бол нийт аж ахуйн нэгжийн 15 хувь нь алдагдалгүй, аж ахуйн нэгжийн 15 хувь нь 20-иос бага хувийн алдагдал хүлээсэн, аж ахуйн нэгжийн 20 хувь нь 20-40 орчим хувийн алдагдал хүлээсэн, үлдсэн 50 хувийн аж ахуйн нэгж нь 40-өөс дээш хувийн алдагдал хүлээсэн гэж хариулжээ.

27. Өрхөд суурилсан утасны судалгааны дүнгээс харахад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 16 хувь нь ямар нэг орлого олоогүй, өмнөх онтой харьцуулахад 73 хувь нь бизнесийн орлого буурсан гэж хариулсан байна. Цалинтай хөдөлмөр эрхэлдэг хүн амын 38 хувийнх нь цалингийн орлого буурсан байна. Гэсэн хэдий ч цалин хөлстэй ажил эрхлэлт нь ажилгүйдэлд өртөхөөс сэргийлсэн байна. (Энэ нь мөн ҮСХ-ны вэб хуудас дахь 2020 оны эхний 2 улирлын ажил эрхлэлтийн тоо мэдээллээр батлагдаж байна).

28. Дээрх мэдээлэлд үндэслэн цар тахлын нөлөөлөлд өндөр өртөх салбарт 60 хувь, дундаж нөлөө үзүүлэх салбарт 40 хувь, бага нөлөө үзүүлэх салбарт 20 хувийн алдагдал хүлээх боломжтой гэж таамаглаж байна. Төрийн өмчит компаниуд болон төрийн байгууллагуудын орлого буураагүй гэж авч үзэх нь зөв юм.

⁷ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Impact_of_COVID-19_on_Business_Activities.pdf&In=En харна уу.

29. Малчдын ноолуурын үйлдвэрлэл, ноолуурын худалдаа арилжаанд муугаар нөлөө үзүүлсэн. Одоогийн байдлаар 1 кг ноолуурын үнэ 48000 орчим төгрөг байгаа бол өнгөрсөн оны 5 дугаар сард 81000 төгрөг байв. Тиймээс алдагдлыг тооцохын тулд 2019 оны 3 дугаар сараас 5 дугаар сарын ноолуурын дундаж үнийг 2020 оны үнэтэй харьцуулж, ноолуураас олох орлогыг ноолуурын үнийн бууралттай ижил хувиар буурсан гэж үзэж болно (алдагдал 50 орчим хувь). ҮСХ болон Дэлхийн банк хамтран зохион байгуулсан коронавирусийн нөлөөллийг тодорхойлох зорилготой өрхөд суурилсан судалгааны дүнгээс харахад малын махны үнэ бага зэрэг нэмэгдсэн хэдий ч малчин болон газар тариалан эрхлэгч өрхүүдийн 70 хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого буурсан, 58 хувь нь бүтээгдэхүүнээ борлуулж чадаагүй гэж мэдэгдсэн байна.

30. Дээрх мэдээлэлд үндэслэн эдийн засгийн салбараас хамаарч хувиараа хөдөлмөр эрхэлдэг эсвэл цалинтай хөдөлмөр эрхэлдэг эсэхээс үл хамааран хөдөлмөрийн орлогыг харгалзан авч үзэж алдагдлыг симуляци хийж болно. Түүнчлэн орлогын бууралтын эрч болон нөлөөлөлд өртөлтийг таамаглалаар зааглаж үзсэн⁸.

31. Малчдын (хөдөө аж ахуй дахь хувиараа хөдөлмөр эрхлэлт) хувьд ажилгүйдлын нөлөө (эсвэл орлогоо бүрэн алдах) байхгүй гэж авч үзсэн боловч дээр дурдсанчлан тэдний орлого нь нийт орлогод ноолуурын орлогын эзлэх хувь хэмжээ болон ноолуурын үнийн бууралтаас хамаарна. Ноолуурын орлого 50 хувиар буурсан гэж авч үзэхэд хөдөө аж ахуйн орлогын дундаж бууралт нь 20 хувь болж байна. Эдийн засгийн бусад салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд зарим салбарын 10 хувь нь огт орлогогүй (ажилгүйдэл), аялал зуучлалын салбарын 50 хувь нь орлогогүй (бүрэн орлогогүй болсон хүмүүсийг санамсаргүйгээр сонгосон) болсон байхад бусад бүхий л салбарын орлогын дундаж бууралт ямар байгааг Хүснэгт 3-ын сүүлийн баганад харуулсан. Салбар тус бүрийн цалинтай ажиллагчдаас санамсаргүй сонгогдсон хүмүүсээс орлогоо алдсан гэж мэдээлсэн хүмүүсийн хувийг Хүснэгт 3-ын эхний баганад, нөлөөнд өртсөн хүмүүсийн дундаж орлогын бууралтыг 2 дахь баганад харуулсан.

32. Дээрх бууралтын дунд санамсаргүй хэсэгт байгаа учраас тооцооллыг 100 удаа давтаж, үр дүнг илүү найдвартай байлгахын тулд дундаж утгыг ашигласан.

⁸ Хэдийгээр салбаруудын бууралтыг таамаглахдаа дундажыг авч үзсэн ч эдгээр нь санамсаргүй хувьсагчтай бөгөөд бууралт нь стандарт хазайлт 10 байхаар санамсаргүй хэвийн тархалттай.

Хүснэгт 3: Эдийн засгийн бууралтын хувилбар тооцоолол (2020 оны 4-9 сар)

Салбар	Цалинтай ажиллагч		Хувиараа хөдөлмөр эрхлэгч	
	бууралттай %	бууралтын %	бүтэн бууралттай %	бууралтын %
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	40	40	0	20*
Уул уурхай, олборлолт	30	30	10	40
Боловсруулах үйлдвэрлэл	30	30	10	40
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	30	30	10	40
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	10	10	10	20
Барилга	30	30	10	40
Бөөний болон жижиглэн худалдаа	30	30	10	50
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	30	30	10	50
Мэдээлэл, холбоо	30	30	10	50
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	10	10	10	20
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	30	30	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	30	30	10	40
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	30	30	10	40
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	0	0	0	0
Боловсрол	0	0	0	0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0	0	0	0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	60	60	-	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	40	40	10	40
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	40	40	10	40
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	40	40	10	40
Аялал жуулчлал	40	40	50	80

Тайлбар: хөдөө аж ахуйн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын бууралт нь ноолуураас олох орлогын бууралтаас хамаардаг. Энэ нь тухайн малчны хувьд ноолуурын орлого хэр зэрэг чухал гэдгээс шалтгаалан хэлбэлздэг. Ерөнхийдөө, бууралтын хувь стандарт хазайлт нь 10 байхаар заасан утгууд дээр төвлөрсөн санамсаргүй хэвийн тархалттай.

33. Дээр дурьдсан бүхий л бууралтыг хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн ажиллаж буй салбарт үндэслэн хувь хүний түвшинд орлогыг шинэчлэн тооцоод, дараа нь өрхийн түвшинд нэгтгэж, өрхийн хөдөө аж ахуйн болон бусад салбарын бизнесийн орлогыг шинэчлэн тооцож нийлбэрийг авсан. Үүний үндсэн дээр бусад эх үүсвэрээс олох орлогыг өрх бүрээр нэмж суурь түвшинтэй харьцуулсан орлогын бууралтын тооцоог тооцсон.

34. Орлогын тооцоолсон бууралтыг өрх бүрээр гаргаж, хэрэглээний зардлыг ижил хувиар буурна гэж үзэн, үүнийг ядуурал ба тэгш бус байдалд үзүүлэх нөлөөллийг тооцоход ашигладаг.

35. Дээр дурьдсан параметрууд хоёр дахин буурсан тохиолдолд орлогод үзүүлэх нөлөөллийг бууруулж симуляцийн боломжит хувилбарыг гаргаж болно. Энэхүү нөхцөл байдал нь эдийн засгийн үйл ажиллагаа болон худалдаа үргэлжлэн сэргэж эхэлснийг харуулж байгаа бөгөөд 2020 оны сүүлийн улирлын нөхцөл байдлыг төлөөлөхүйцээр сонгосон.

3 Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ

36. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед эдийн засгийг эрчимжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газраас олон цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна.

37. Эхний цогц арга хэмжээг 2020 оны 4 сараас 9 дүгээр сард буюу эхний хагас жилд 2 багц арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн (эхний багц хөтөлбөрийг 3 сарын сүүлээр, 2 дахь багц хөтөлбөрийг 5 сарын эхээр зарласан). Цогц хөтөлбөрт дараах арга хэмжээг хамруулсан байна.

Эхний багц хөтөлбөрийг 2020 оны 3 дугаар сарын 27-нд зарласан.

- Аж ахуйн нэгжийг нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс 6 сарын хугацаатай чөлөөлөх. Энэ нь ажил олгогчид ашиг тус үзүүлэхээс гадна сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлдөг цалинтай ажиллагчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үр ашгаа өгнө.
- Иргэдийн цалин, хөлсний орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх (төрийн албан хаагчид хамаарахгүй)
- Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг орлогын татвараас 6 сарын хугацаанд чөлөөлөх
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдсон хэдий ч тухайн аж ахуйн нэгж ажлын байраа хадгалж байгаа бол дээрх аж ахуйн нэгжийн ажилтнуудад 2020 оны 4 сараас 6 сарын хооронд сар бүр 200,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх
- Малчдаас ноолуур худалдан авахад дэмжлэг үзүүлж 3 хувийн хүүтэй зээл олгох
- 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмж 20,000 төгрөгийг 10,000 төгрөгөөр нэмэгдүүлж, 30,000 төгрөг болгох
- Бүх төрлийн шатахууны үнийг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 1 литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулах.

2 дахь багц хөтөлбөрийг 2020 оны 5 дугаар сарын 6-нд танилцуулсан.

- 0-18 насны хүүхдэд олгож буй тэтгэмжийг 9 дүгээр сарыг дуустал сар бүр 100,000 төгрөг болгон нэмэгдүүлж олгоно. Өмнөх багц хөтөлбөрт зарласан дүнтэй харьцуулахад 70,000 төгрөгөөр нэмэгдсэнийг харуулж байна.
- Бага орлоготой өрхийн насанд хүрсэн хүнд сар бүр олгодог хүнсний эрхийн бичиг олгох хөтөлбөрийн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 5 сарын 1-нээс 10 сарын 1-нийг хүртэл хугацаанд 2 дахин нэмэгдүүлэх
- Нийгмийн халамжийн тэтгэвэр авагчид (нийгмийн даатгалгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаггүй ахмад настан, бүтэн өнчин, хагас өнчин, өрх толгойлсон 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эцэг эх)-ын тэтгэмжийг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлэн 5 сар (5 сараас 9 сард)-ын хугацаанд нийт 280,000 төгрөг олгох
- Малчдын орлогыг дэмжих зорилгоор малчин өрхөд ноолуурын 1кг тутамд 20,000 төгрөгөөр тооцож татаас олгох.

38. Хоёр дахь багц арга хэмжээг 2020 оны 10 сараас 12-р сард хэрэгжүүлнэ. Энэ багц арга хэмжээний хүрээнд бодлогын зарим арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, заримыг нь зогсооно. Үүнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

- Хүүхдийн мөнгө хөтөлбөр, хүнсний эрхийн бичиг хөтөлбөр, нийгмийн халамжийн тэтгэврийг нэмэгдүүлсэн хэмжээгээр энэ оныг дуустал дахин 3 сар үргэлжлүүлэн олгох
- Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтийг дуусгавар болгов. Нийгмийн даатгалын шимтгэлийг аж ахуйн нэгж байгууллага, даатгуулагч тус бүр 5.0 хувиар тооцож, бууруулж төлөх
- Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг орлогын татвараас энэ оныг дуустал чөлөөлөх

39. Энд дурдагдаагүй бусад арга хэмжээнүүд, тухайлбал, Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарт шаардлагатай тоног төхөөрөмж авах, бэлэн байдлыг хангах зэрэг маш чухал арга хэмжээнүүд нь өрхийн аж байдалд үзүүлэх эдийн засгийн нөлөөллийн үнэлгээнд ач холбогдол багатай юм.

40. Үүнээс гадна дээр дурьдсан бүх арга хэмжээг энэхүү үнэлгээнд хамруулан симуляци хийж болохгүй юм. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь ажлын байрыг хадгалахад нөлөө үзүүлэх боловч хямралын улмаас аж ахуйн нэгжүүд ажилтнуудаа цомхотгосноос болж ажилгүйдэл багассан, эсвэл нэмэгдсэн гэж үзэн цочролын нөлөөллийн таамаглалыг аль хэдийнэ тооцсон байгаа.

41. Эдгээр үр дүн нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт, жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварын хөнгөлөлт, ажлын байрыг хадгалахад зориулсан татаас зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсэнээр бий болсон. Үүнтэй адил нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, шатахууны үнийг бууруулахад үзүүлэх үр нөлөөг дахин тооцоолохгүй.

42. Өрхийн орлогод шууд нөлөө үзүүлэх засгийн газрын бодлогын арга хэмжээнд анхаарлаа төвлөрүүлж, ялангуяа дараах арга хэмжээг бид авч үзсэн болно:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт, хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх (төрийн албан хаагчид хамаарахгүй)
- Хүүхдийн мөнгө хөтөлбөр, хүнсний эрхийн бичгийн хөтөлбөр, нийгмийн халамжийн тэтгэврийн нэмэгдэл
- Ноолуурын үнийн урамшуулал олгох

3.1 Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлт

43. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх эхний алхам нь хэнд зориулж гаргасан бэ гэдгийг тодорхойлох явдал юм. Энэ нь 2 өөр арга хэмжээ мэт боловч тухайн шалгуурыг хангах нэг хүн хамрагдах боломжтой арга хэмжээ юм. Албан секторт хөдөлмөр эрхэлж байгаа цалинтай ажиллагчийн нийт цалингаас төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэл (2 хувь), нийгмийн даатгалын шимтгэлийг (9.5 хувь болгон) бууруулж, үлдэх дүнгээс хувь хүний орлогын татварын 10 хувийг суутгадаг боловч зарим орлогын (цалингийн интервалаас хамаарна) хувьд чөлөөлөгддөг⁹. Ажил олгогч ихэнхдээ дээрх цалинг хэвээр нь байлгадаг. Иймээс, Засгийн газрын хэрэгжүүлсэн дээрх бодлогын үр дүнд бүх цалинтай ажиллагчдын цэвэр цалин өсчээ.

⁹ Сарын татварын чөлөөлөлт: 500,000 хүртэлх төгрөгийн цалинтай бол 20,000 төгрөг; 0.5-1.0 сая төгрөгийн цалинтай бол 18000; 1-1.5 сая төгрөгийн цалинтай бол 16000; 1.5-2.0 сая төгрөгийн цалинтай бол 14000; 2.0-2.5 сая төгрөгийн цалинтай бол 12000; 2.5-3.0 сая төгрөгийн цалинтай бол 10,000 төгрөг байдаг.

44. Жишээ нь: 1.8 сая төгрөгийн цалинтай иргэний НДШ болон ХХОАТ-аас чөлөөлөгдөхөөс өмнөх цэвэр цалин нь 1.447 сая төгрөг¹⁰ байсан бол бодлогын арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш цэвэр цалин 1.764 сая төгрөг болж өсжээ. (зөвхөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэвээр төлөгдөнө). Эндээс харахад ажиллагчийн цэвэр цалингийн хэмжээ мэдэгдэхүйц өссөн байна.

45. Түүнчлэн, ажиллагчийн төлөх шимтгэлээс гадна ажил олгогч нь осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалтай холбоотойгоор салбарын онцлогоос хамааран 10.5-12.5 хувийн (эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг оруулаагүй) шимтгэлийг төлдөг. Ийнхүү компаниудын төлөх шимтгэлийн хэмжээ буурсанаар ажил олгогчид шууд, ажиллагчдад шууд бусаар ашиг тусаа өгч, ажилтнуудаа авч үлдэх, эдийн засгийн идэвхжлийг дэмжих хөшүүрэг болдог.

46. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг бөгөөд сайн дурын нийгмийн даатгалд хамрагддаг эсвэл сайн дураараа нийгмийн даатгалд хамрагддаг иргэдэд хандсан урамшууллыг мөн гаргасан. Онолын хувьд, сайн дурын нийгмийн даатгалд хамрагдах иргэн өөрийн орлогын 13.5 хувийг шимтгэлд төлөх ёстой боловч сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 420,000 төгрөгтэй уялдуулан (хамгийн бага хэмжээгээр буюу сард 56,700 төгрөг) төлдөг.

47. 526,000 орчим ажиллагчид ХХОАТ-аас чөлөөлөгдөж, мөн тэр хэмжээний ажиллагчид НДШ төлөлтөөс чөлөөлөгдөн ашиг тус хүртсэн гэж Сангийн яамнаас тооцсон бөгөөд үүнтэй зэрэгцээд 180,000 орчим иргэн сайн дурын даатгалд хамрагдана гэсэн тооцооллыг хийсэн.

48. ӨНЭЗС-гаар зөвхөн цэвэр цалинг гаргах боломжтой боловч энэхүү цалингийн дүнгээс төлөх шимтгэл, татварын хувь болон татварын чөлөөлөлтийг мэдэж байгаа болохоор цалинтай ажиллагч болгоны цалингийн өсөлтийг загварчилж болно. Гэхдээ бид албан секторт ажилладаг болон сайн дураараа нийгмийн даатгал төлдөг хүмүүсийг тодорхойлох хэрэгтэй. Энэхүү мэдээллийг эрүүл мэндийн даатгал төлөлтийн тайлан (сайн дурын даатгалд хамрагдсан болон ажил олгогчоор дамжуулан хамрагдсан, 2018 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ)-гаас шууд гарган авсан.

49. ӨНЭЗС-гаар хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг, нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг эсэх талаар тусгайлсан асуултууд асуудаг учраас тэтгэмжийн өсөлтийг тооцоход хялбар байсан. Гэхдээ 2018 онд хүүхэд бүрд хүүхдийн мөнгө олгохгүй байсан тул 18 хүртэлх насны бүх хүүхдэд нэмэлт дэмжлэг (сард 80,000 төгрөг) олгож эхэлсэн гэж тооцоололдоо тусгасан. Хүнсний эрхийн бичиг хөтөлбөрт хамрагддаг иргэдийн тоо ӨНЭЗС-гаар ойролцоогоор 240,000 гэж гарсаныг дутуу тооцсон гэж үзээд хүнсний эрхийн бичиг аваагүй боловч авах боломжтой 50,000-ыг нэмж оруулсан¹¹.

50. Эцэст нь, ноолуурын үнийн татаасыг тооцоходоо ӨНЭЗС-нд малчдын худалдан борлуулсан гэж мэдээлсэн хэмжээг ашигласан. Сангийн яамнаас 230,000 малчинд нийт 175 сая төгрөгийн татаасыг олгоно гэжээ.

51. Хүснэгт 4-т хэд хэдэн бодлогын арга хэмжээнд хамрагдсан хүн амын тоо болон төсвийн тооцооллыг нэгтгэн харуулав. Бодлогын хэрэгжилтийн үр шимийг хүртэгсдийн тоог гаргахдаа 3 тооцоог хийлээ. Үүнд: үр шимийг шууд хүртэгсэд (жишээ нь: хүүхдүүд, хөдөлмөр эрхлэгчид, малчид), дэмжлэг туслалцаа авсан өрх болон хүн амын хувь. Өрхийн аль нэг гишүүн нь хэрэгжүүлсэн бодлогын үр шимийг хүртсэн бол тэдний өрхийн бүх гишүүд тодорхой хэмжээгээр үр шим хүртэж байгаа гэж үзээд тухайн өрхийг үр шим хүртсэн гэдэгт оруулсан. Мөн 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд

¹⁰ Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 36000, Нийгмийн даатгалын шимтгэлийн 171,000, ХХОАТ-ын 145,300-ын хасаж гаргадаг. Нийт цалингаас эрүүл мэндийн + нийгмийн даатгалын шимтгэлийг хасаж, үлдсэн дүнгээс 10 хувийн татвар суутган, татвараас чөлөөлөгдөх орлого 14000 (1.5-2 сая төгрөгийн орлоготой хүмүүсийн хувьд)-г нэмж гаргана.

¹¹ Хамрагдах боломжийг ООТА-ын оноо болон шалгуурын босгыг ашиглан тооцсон

хэрэгжүүлсэн бүхий л төрлийн бодлогын үр шимийг хүртэгсэд сар бүр дэмжлэг аваагүй ч тухайн хугацаанд дэмжлэг авсан хүмүүсийг тоонд оруулж тоолсон. Ялангуяа, хүнсний эрхийн бичиг хөтөлбөрт хамрагдагчид, нийгмийн халамжийн тэтгэвэр авагчид 6 биш, 5 сарын турш дэмжлэг авсан байдаг. Төсвийг тооцохдоо бүхий л хугацааны туршид зарлага гарсан гэж үзсэн бөгөөд зарим зардал нь зөвхөн тухайн саруудад гарсан гэдгийг харгалзан засварласан.

Хүснэгт 4: ӨНЭЗС дахь бодлогын арга хэмжээнд хамрагдалт, төсөв (2020 оны 4-9 сар)

Бодлогын гол арга хэмжээ	Үр шим хүртэгчид			Төсөв	
	Хүний тоо (мянган хүн)	Өрх	Хувь: Хүн ам	(тэрбум төгрөг)	2018 оны ДНБ-д эзлэх хувь
Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсэн	1174.6	64.0	79.8	563.8	1.74
ААН-ийн НДШ-ийг чөлөөлсөн				325.2	1.00
НДШ, ХХОАТ-ыг чөлөөлсөн	513.0	43.6	49.0	574.6	1.77
Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн НДШ-ийг чөлөөлсөн	187.7	15.3	17.0	63.9	0.20
Нийгмийн халамжийн тэтгэвэр	87.9	8.7	9.9	44.0	0.14
Хүнсний эрхийн бичгийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн	259.2	5.4	8.1	15.6	0.05
Ноолуурын үнийн урамшуулал	173.6	19.5	20.4	134.7	0.42
Нийт				1721.8	5.31

Эх үүсвэр: ӨНЭЗС – 2018 -д үндэслэсэн тооцоолол.

52. Ерөнхийдөө судалгаагаар гарсан тооцоо нь СЯ-наас мэдээлсэн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцангуй ойролцоо дүнтэй гарсан байна. Жишээ нь: СЯ-наас хүүхдийн мөнгө хөтөлбөрт 552.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байхад, ӨНЭЗС-ны үр дүнгээр тооцсон дүн 564.0 тэрбум төгрөг, мөн нийгмийн халамжийн тэтгэврийн төсөв адил дүнтэй гарсан байна. Харин нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөд зориулсан төсвийн хувьд ялгаатай үр дүн гарч байна. СЯ нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт болон нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хоцорсон төлөлт болон торгуулиас чөлөөлөхөд 870 тэрбум төгрөг, мөн хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлтөд тусад нь 175 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Бид торгууль болон шимтгэлээс чөлөөлөлтийн хэмжээг мэдэхгүй ч эдгээр нь төдийлөн их биш гэж үзсэн. Гэхдээ ажил олгогчдод олгох чөлөөлөлтийг багтаасан НДШ-ийн чөлөөлөлт болон ХХОАТ-ын чөлөөлөлтийг нэгтгэн тооцоход нийт 964 тэрбум төгрөг гэж гарсан. Хэдийгээр бага зэрэг ялгаа гарсан ч үндсэндээ ойролцоо хэмжээтэй гарсан. Эцэст нь, ӨНЭЗС-ны дүнгээс тооцсон малчдад олгосон ноолуурын татаас СЯ-ныхаас доогуур гарсан ч бас л ойролцоо хэмжээтэй байна.

53. Эдгээр бүх арга хэмжээнд зарцуулсан төсвийг нэгтгэн тооцоход ердөө 6 сарын төсөв нь 2018 оны ДНБ-ий 5.12%-тай тэнцэж байгаа бөгөөд эдгээр саруудад ДНБ-ий 10%-тай тэнцэх мөнгийг зарцуулсан байна.

54. Төсвийн хэмжээг тооцохдоо 2020 оны тоог ашигласан ч хэрэглээний зарлагад нөлөөлөх нөлөөллийг тодорхойлохдоо 2018 оны үнэд шилжүүлэн тооцсон.

55. Ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтийг тооцохоос өмнө өрхийн орлого, хэрэглээнд нөлөөлсөн эцсийн нөлөөллийг гаргахын тулд дээрх бодлогууд болон орлогын өсөлтийг Ковид-19 гарсан үеийн бууралттай хамтатган авч үзсэн.

56. Эцэст нь 2020 оны сүүлийн улиралд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулах төсөв, түүний үр шимийг хүртэх хүмүүсийн тоог тооцсон. Үр дүнг Хүснэгт 5-аас харахдаа НДШ-ийн төсвийн бууралт, ХХОАТ-аас цаашид чөлөөлөхгүй болсныг анхаарах хэрэгтэй. ӨНЭЗС-гаар төсвийг 167.4 тэрбум төгрөг гэж тооцоолсон байхад СЯ-наас 144.4 гэж мэдээлсэн нь ойролцоо гарч байна. СЯ-наас ХМХ, нийгмийн халамжийн тэтгэвэрт 322 тэрбум төгрөг олгохоор тооцсон байхад ӨНЭЗС-ны тооцоогоор 308 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 5: ӨНЭЗС дахь бодлогын арга хэмжээнд хамрагдалт, төсөв (2020 оны 10-12 сар)

Бодлогын гол арга хэмжээ	Үр шим хүртэгчид			Төсөв		
	Хүний тоо (мянган хүн)	Өрх	Хувь: Хүн ам	(тэрбум төгрөг)	2018 оны ДНБ- д эзлэх %	
Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсэн	1174.6		64.0	79.8	281.9	0.87
Аж ахуйн нэгжийн НДШ-ийг бууруулсан					98.9	0.31
НДШ-ийг бууруулсан	524.8		44.5	49.9	68.5	0.21
Нийгмийн халамжийн тэтгэвэр	87.9		8.7	9.9	26.4	0.08
Хүнсний эрхийн бичгийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн	259.2		5.4	8.1	9.4	0.03
Нийт					485.1	1.50

Эх үүсвэр: ӨНЭЗС – 2018 -д үндэслэсэн тооцоолол.

57. 2020 оны сүүлийн улиралд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийн нөлөөллийг өмнөхтэй адилаар эдийн засгийн бага зэрэг сөрөг нөлөө болон өрхийн орлогын дээрх нөлөөлөлтэй хамтатган үнэлж болно.

4 Үр дүн

58. Дээр дурдсан эдийн засгийн бууралтын талаарх төсөөллийг ашиглан цар тахал өрхийн бодит орлогыг дунджаар 10%-иар бууруулах байсан гэдгийг тогтоосон. Энэ нь ҮСХ-ны мэдээлсэн нэг болон хоёрдугаар улирлын ДНБ-ий бууралттай ойролцоо байна. Хүснэгт 6-д үзүүлснээр суурь үеийн орлогоосоо 50%-иар бага орлоготой болсон хүн ам нийт хүн амын 2.5 хувь байхад хүн амын 12 орчим хувь нь 50-75%-ийн бага орлоготой, хүн амын 46% хувь нь 75-100%-ийн бага орлоготой байна. Мөн орлого нь өөрчлөгдөөгүй, эсвэл нэмэгдсэн хүмүүс (Хавсралт А нь орлогын тархалтын өөрчлөлтийг суурь үе болон цар тахлын эдийн засгийн хямралд өртсөн хүмүүсийн орлоготой харьцуулан дүрсэлсэн) байгаа учраас дээрх дундаж нь ерөнхий өөрчлөлтийг харуулж байна. Энэ нь 4-9 сард нийгмийн хамгааллын голлох хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлээгүй байсан бол гэж үзсэн нөхцөл юм.

59. Гэхдээ Засгийн газрын бодлогын бууруулах нөлөөллийг авч үзэхэд энэхүү бодлого нь цар тахлын сөрөг нөлөөг арилгаж, хүмүүсийн орлого суурь үеийн орлоготой харьцуулахад дунджаар 16% нэмэгдсэн байна. Хэдийгээр зарим хүмүүсийн орлого буурсан ч нөгөө хэсгийнх нь орлого улам их нэмэгдсэн тохиолдол ч байна.

60. КОВИД-19 болон бодлогын нөлөөллийг 2020 оны сүүлийн улирлын хувьд тооцохдоо 4-өөс 9 дүгээр сарыг дуустал хугацааны бууралтын 50 орчим хувьтай тэнцэх бууралттай байна гэж төсөөлөн бодлого арга хэмжээ энэ оныг дуустал хэвээр үргэлжлэнэ гэж авч үзсэн.

Хүснэгт 6: Суурь үетэй харьцуулсан 2020 оны орлогын дундаж, тархалтын өөрчлөлт

	4 сараас 9 сар	10 сараас 12 сар
Ковидын нөлөөлөл		
Орлогын өөрчлөлтийн %	-10.3	-4.0
Тархалт:		
<50%	2.5	0.7
50-75%	11.6	2.5
75-100%	46.3	46.3
өөрчлөлтгүй/өсөлт	39.5	50.6
Нийт	100.0	100.0
Бууруулах нөлөөлөл		
Орлогын өөрчлөлтийн %	16.3	14.2
Тархалт:		
<75%	4.3	1.5
75-100%	16.1	14.2
100-125%	47.7	64.2
>125%	31.9	20.1
Нийт	100.0	100.0

Эх үүсвэр: ӨНЭЗС – 2018 -д үндэслэсэн тооцоолол.

61. Орлогын бууралт хэрэглээний зарлагыг тэнцүү хэмжээгээр бууруулна гэж үзвэл тэгш бус байдал болон ядуурлын нөлөөллийг хэмжиж болно¹². Тэгш бус байдал (Жини коэффициент хэрэглэж) болон ядуучуудын хувийг албан ёсны улсын ядуурлын шугамыг (энэ нь 2018 оны үнээр сард 166580.3 төгрөгтэй тэнцүү байна) ашиглан мөн доод болон дээд ядуурлын шугамыг¹³ (энэ нь 2018 оны үнээр сард тус тусын 127724.5 төгрөг болон 218613.9 төгрөгтэй тэнцүү) ашиглан өөр өөр нөхцөлд хэмжсэн.

62. Хүснэгт 7 нь суурь үед, цар тахлын нөлөөтэй үед болон цар тахлын нөлөөллийг бууруулах нийгмийн хамгааллын бодлого хэрэгжих үеийн үр дүнг нэгтгэн харуулж байна. Энэ нь Засгийн Газраас арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй бол тэгш бус байдал болон ядуурал мэдэгдэхүйц нэмэгдэхээр байсан бөгөөд Засгийн газрын бодлогууд нь сөрөг нөлөөллөөс зайлсхийхээс гадна ядуурлыг суурь үетэй харьцуулахад улам багасгахаар байна.

Хүснэгт 7: Ядуурал болон тэгш бус байдлын хэмжүүр – 2020 оны 4-9 сар

	Тэгш бус байдал: Жини коэффициент	Албан ёсны ядуурлын шугам	Доод ядуурлын шугам	Дээд ядуурлын шугам
Суурь үе	0.327	28.4	13.9	46.5
Цар тахлын нөлөө	0.339	36.7	20.7	55.1
Бууруулах арга хэмжээ	0.306	17.6	6.4	37.5

Эх үүсвэр: ӨНЭЗС – 2018 -д үндэслэсэн тооцоолол.


63. Цар тахал гарахаас өмнөх үе буюу суурь үед ядуучуудын хувь 28.4% байсан нь эдийн засгийн хямралаас шалтгаалан 36.7% болж өсөх байсан боловч нийгмийн хамгааллын бодлогын үр нөлөөгөөр 17.6% болж буурсан байна. Ядуурлын дээд болон доод шугамын хувьд мөн тооцооллыг хийсэн.

64. Зураг 2-т суурь үе, цар тахлын нөлөөтэй болон нийгмийн хамгааллын бодлого хэрэгжсэн үеийн өсөн нэмэгдэх тархалтын функцыг харууллаа. Хэрэглээний зардлын түвшин бүрт 'х' гэж авч үзвэл өсөн нэмэгдэх тархалтын функц нь х-тэй тэнцүү эсвэл доогуур хэрэглээтэй хүн амын хувийг харуулж байна. Цар тахал нь муруйг зүүн тийш шилжүүлж нийтдээ хэрэглээний зардлыг бууруулж байгаа хэдий ч бодлогын арга хэмжээ нь муруйг ялангуяа тархалтын доод хэсгийг мэдэгдэхүйц үр ашигтайгаар баруун тийш шилжүүлж байна.

¹² Энэ нь Монгол Улсад орлогын оронд хэрэглээний зардлыг тархалтын шинжилгээнд ашигладаг.

¹³ Нэн ядуу өрх болон тархалтын дундах өрхийн боломжит нөлөөллийг тодорхойлохын тулд ядуурлын доод болон дээд шугамыг тооцдог.


Зураг 2: Өсөн нэмэгдэх тархалтын функц - 2020 оны 4-9 сар



65. Мөн авч хэрэгжүүлсэн бодлогуудын нөлөөлөл, ялангуяа хамгийн том бөгөөд төсвийг нь харьцуулах боломжтой 2 арга хэмжээ болох НДШ/ХХОАТ чөлөөлөлт болон ХМХ-ийн нэмэгдлийн нөлөөллийг тус тусад нь гаргах боломжтой. Хэрвээ Засгийн Газар зөвхөн НДШ/ХХОАТ чөлөөлөлтийг хэрэгжүүлсэн бол албан ёсны ядуурлын шугамаас доош орох хүмүүсийн хувь 30.5 байх бөгөөд энэ нь цар тахлын нөлөөнд байснаас бага хэдий ч КОВИД-оос өмнөх үетэй харьцуулбал өндөр байна.

66. Зөвхөн ХМХ-ийн нэмэгдлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийж үзэхэд ядуурлын хувь 24.9 болж буурч байна. Тиймээс ХМХ-ийн нэмэгдэл нь дангаараа цар тахлаас хамаарсан ядуурлын нөлөөг бууруулахаар байна (Зураг 3-ыг харна уу). Түүнчлэн, зөвхөн ХМХ-ийн нэмэгдэл нь Жини коэффициентийг 0.307 болгож бууруулж байхад НДШ болон татварын чөлөөлөлт нь Жини коэффициентийг 0.342 болгож өсгөхөөр байна.

Зураг 3: Өөр өөр хувилбараар тооцсон ядуу хүн амын эзлэх хувь - 2020 оны 4-9 сар



67. Хүснэгт 8-д авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний төсөв хүн амын 5 тэнцүү бүлэгт хэрхэн хуваарилагдсаныг цар тахал нөлөөлсөн хэрэглээний тархалтыг ашиглан тооцсоныг харуулж байна. Хүснэгтээс НДШ/ХХОАТ-ын чөлөөлөлтөд зарцуулсан төсвийн 39% нь хүн амын чинээлэг 20%-д очиж байхад ердөө 9% нь ядуу 20%-д очиж байгаа нь энэхүү чөлөөлөлт нь боломжийн амьдралтай хүмүүст хуваарилагдсан нь харагдаж байна. Үүнтэй харьцуулахад, ХМХ-ийн төсвийн 26.4% нь хүн амын ядуу 20%-д очиж байхад ердөө 13.2% нь чинээлэг 20%-д очиж байна. ХЭБХ нь орлого дахин хуваарилалтыг илүү сайн хийдэг бодлого хэдий энэ нь харьцангуй бага төсөвтэй бөгөөд бага цар хүрээг хамардаг. Нийгмийн халамжийн тэтгэвэр нь орлогын дахин хуваарилалтыг хийж чадсан. НДШ-ийн чөлөөлөлт нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд (хувиараа нийгмийн даатгал төлдөг) бага зэрэг нөлөөтэй, харин малчдад үзүүлж буй дэмжлэг нь төдийлөн нөлөөгүй байна.

Хүснэгт 8: 4-9 сарын төсвийн тархалт, хүн амын тооны таван тэнцүү бүлгээр, бодлогын төрлөөр


	НДШ, ХХОАТ-ын чөлөөлөлт	Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн НДШ	Малчид	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	Нийгмийн халамжийн тэтгэвэр	Хүнсний эрхийн бичиг
Төсөв	574.1	63.9	134.7	563.8	44.0	15.6
Тархалт, хүн амын тэнцүү тооны 5 бүлгээр:						
Ядуу	8.9	19.2	17.2	26.4	23.7	62.4
II	13.1	23.6	21.5	23.2	23.2	22.4
III	17.0	22.1	22.9	20.1	21.3	9.8
IV	22.0	20.0	21.3	17.1	18.7	3.7
Чинээлэг	39.0	15.1	17.1	13.2	13.1	1.7
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: 2018 оны ӨНЭЗС-нд ү

68. Хүснэгт 8-д төсвийн хуваарилалтыг бодит хэмжээгээр харууллаа. Хэдийгээр дээд болон доод 5 тэнцүү бүлэгт яг адил хэмжээгээр хуваарилсан ч хүн амын 5 тэнцүү

бүлгийн хувьд доод бүлгийн орлого нь дээд бүлгийнхээс илүү өснө. Энэхүү нөлөөллийг Зураг 4-т үзүүлсэн. Хямралын дараах хэрэглээнд нь тулгуурлаж, хүн амыг хамгийн ядуугаас хамгийн чинээлэг гэж эрэмбэлэн хэрэглээний өөрчлөлтийг суурь үетэй харьцуулан ялгаатай хувилбар бүрт ямар байхыг энд харуулж байна. Дундаж центайл (centile) утгыг ашиглан графикийг зурсан (Центайл тус бүр нь хүн амын 1%-ийг агуулна). Энэ нь тахал өвчнөөс шалтгаалан нийтдээ дордсон ба НДШ/ХХОАТ-ын чөлөөлөлт нь бүхий л бүлгийг дэмжиж байгаа хэдий ч хүн амын доод хагасыг суурь түвшнөөс доогуур үлдээж байгааг харуулж байна. Үүнтэй харьцуулахад ХМХ-ийн нэмэгдэл нь доод бүлгүүдэд харьцангуй илүү дэмжлэг үзүүлэх бөгөөд цар тахлын нөлөөг бүх хүмүүст бууруулж байна. Нийгмийн хамгааллын цогц арга хэмээний үр дүнд гарсан өөрчлөлт нь тархалтын туршид эерэг байгаа бөгөөд доогуур хэрэглээтэй бол энэ өөрчлөлт нь их, улмаар хэрэглээ өсөх тусам өөрчлөлт багасах хандлагатай байна. Хамгийн ядуу хүмүүсийн хэрэглээ суурь үетэй харьцуулахад доошилсон байна.

Зураг 4: 2020 оны 4-9 сар – Суурь үетэй харьцуулсан нэг хүнд ногдох хэрэглээний зардлын өөрчлөлтийн хувь (цочролын дараах хэрэглээгээр эрэмбэлсэн)




69. Нийгэм-эдийн засгийн бүлгүүдэд хэрхэн нөлөөлснийг авч үзэхдээ илүү задаргаатайгаар үнэлэх хэрэгтэй. Зураг 5-д ядуучуудын хувийг өрхийн төрлөөр, 3 өөр нөхцөл байдлаар: КОВИД-оос өмнөх үе, цар тахлын эдийн засгийн нөлөөтэй үе болон эдийн засгийн хямралыг бууруулах чиглэлээр нийгмийн хамгааллын арга хэмжээ авсны дараах үеүүдийг харьцуулан авч үзлээ.

70. Энэ нь хүүхэдтэй бүхий л төрлийн өрхүүдийн ядуурал суурь түвшинтэй харьцуулахад буурсныг харуулж байгаа бөгөөд хүүхэдгүй хосууд, нэг хүнтэй өрх болон насанд хүрсэн гишүүдээс бүрдсэн өрхүүдийн ядуурал нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ч нэмэгдсэн эсвэл нэг хэвэндээ байна. Гэсэн хэдий ч дээрх өрхүүдийн ядуурлын түвшин хүүхэдтэй өрхүүдээс хамаагүй бага байна.

71. Хавсралт А-д байршил, газарзүйн бүс, хүүхдийн тоо, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэсэн задаргаагаар харуулсан. Түүнчлэн, ядуурлын хувийг доод болон дээд ядуурлын шугамтай харьцуулсан (Хүснэгт 14-ийг харна уу). Хавсралт

хүснэгтэд хүн амын дэд бүлгүүдийн ядуурлын нөлөөллийг эхлээд зөвхөн ХМХ-ийн нэмэгдэл, дараа нь НДШ/ХХОАТ-ын чөлөөлөлтийн хувьд үзүүлсэн.

Зураг 5: Ядуу хүн амын хувь, өрхийн төрлөөр, гурван өөр хувилбараар: суурь үе, КОВИД-19 ба нийгмийн хамгааллын арга хэмжээ - 2020 оны 4-9 сар



72. Эцэст нь цар тахлын эдийн засгийн нөлөө буурсан ч (4 сараас 9 дүгээр сарын симуляцийн бууралтын тал нь), дэмжлэгийн өөр багц арга хэмжээ хэрэгжиж байна гэж үзэн 2020 оны сүүлийн улирлын хувьд тооцоолол хийсэн. Хүснэгт 9-д үндсэн үр дүнг харууллаа. Төсөөлсний дагуу цар тахлын сөрөг нөлөө нь ядууралд бага зэрэг нөлөөлж байгаа хэдий ч Засгийн Газрын арга хэмжээ нь нөлөөллийг багасгаж ядуурлын түвшинг бүр суурь түвшинтэй харьцуулахад ч багасгаж байна.

Хүснэгт 9: Ядуурал болон тэгш бус байдлын хэмжүүр – 2020 оны 4-р улирал

	Тэгш бус байдал: Жини коэффициент	Албан ёсны ядуурлын шугам	Доод ядуурлын шугам	Дээд ядуурлын шугам
Суурь үе	0.327	28.4	13.9	46.5
Цар тахлын нөлөө	0.329	31.1	15.9	49.6
Бууруулах арга хэмжээ	0.297	17.3	5.9	38.1

5 Бодлогын Хариу Арга Хэмжээний Хувилбарууд

73. 2020 оны 9 дүгээр сар хүртэлх тоон мэдээлэл бүхий статистикийн хамгийн бюллетенээс харахад боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн¹⁴ салбарын аль алинд өсөлт гарсан нь эдийн засаг сэргэж эхэлсэний дохио болж байна. Гэсэн хэдий ч зарим салбар тухайлбал, зочлох үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт тулгарч буй бэрхшээлүүд үргэлжлэх төлөвтэй байна.

74. Энэ нь Монгол Улсын Засгийн газар бодлогын үндсэн сонголтуудын тогтолцоогоо бэхжүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн хямралд нэрвэгдсэн хүмүүст дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот стратегийг боловсруулах шаардлагатайг харуулж байна.

75. Зарим бодлого нь бусадтай харьцуулахад дахин хуваарилалт сайтай болох нь батлагдсан тул 2021 онд авч хэрэгжүүлэх бодлогоо тодорхойлоход дээрх бодлогыг илүү анхааралтай авч үзэх хэрэгтэй.

76. Цар тахалд өртсөн салбарын (аялал жуулчлал) ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр дамжуулан дэмжих, мөн орлого орлуулан тооцох арга (ООТА)-аар өрхийн амьжиргааг тодорхойлсон үнэлгээний мэдээллийг агуулсан өрхийн мэдээллийн нэгдсэн сан (ӨМНС)-г ашиглах гэсэн боломжит хувилбарууд байна.

77. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг ашиглан юу хийж болохыг бид авч үзсэн.

78. ӨМНС-гийн хамгийн сүүлийн мэдээлэл нь 2017 оны мэдээлэл бөгөөд ООТА-ын моделийг 2014 оны ӨНЭЗС-ны мэдээллийг ашиглан тооцсон байдаг. Иймээс зорилтот бүлгийг тодорхойлоход дараах гурван төрлийн алдаа гарч болно. Үүнд:

- Загварчлалын алдаа: прокси тест учраас энэ нь ямар ч загвар ашигласан тодорхой хэмжээний алдаа гарах нь ойлгомжтой;
- Хэрэгжүүлэлтийн алдаа: судалгааны мэдээлэл цуглуулахад алдаа гаргасан эсвэл хүмүүс өөрсдийн нөхцөл байдлыг буруу мэдээлсэн;
- 2017 оноос хойш ялангуяа цар тахлаас шалтгаалж өрхүүдийн нөхцөл байдал өөрчлөгдсөн.

79. Дэлхийн Банкнаас¹⁵ саяхан гаргасан тайланд эхний болон 2 дахь асуудлыг авч үзсэн байсан бөгөөд бид нийгмийн халамжийн хуваарилалтыг өөрчлөхөд цар тахлын болзошгүй нөлөөллийн дүн шинжилгээг танилцуулж байна.

80. Хүснэгт 10 нь хүн амын 20%, 30%, 40% болон 50% зэрэг янз бүрийн хувийг хамарсан бөгөөд ХМХ-ийн үр шимийг хүртэгчид болон ООТА-ын оноонд үндэслэн зорилтот хүн амд чиглэсэн тэтгэмжийн тархалтыг харуулж байна. Хүнсний эрхийн бичиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ООТА-ыг ашигладаг бөгөөд энэ хөтөлбөр хүн амын ердөө 8%-д хүрдэг. Хүснэгт 10-т хүн амын 5 тэнцүү бүлэг тус бүрийн хамрагдалтыг харуулахдаа өрхийн гишүүдийн хэн нэг нь шилжүүлэг авсан тохиолдолд тэдний өрхийн бүх гишүүдийг тэтгэмж авагч гэж үзсэн. Дээрх шилжүүлэг хүн амын илүү их хувийг хамарч байвал хүн амын 5 тэнцүү бүлгээс доогуур хэрэглээтэй бүлгийн хүн амын хамрагдалт өндөр байх бөгөөд энэ нь орхигдох магадлалыг бууруулдаг. ӨНЭЗС-ны

¹⁴ Монгол Улсын нийгэм-эдийн засгийн байдал, ҮСХ, 2020 оны 9-р сар, хуудас 95, (<https://www.en.nso.mn/content/341>).

¹⁵ Монгол Улсад үр дүнтэй нийгмийн халамжийг бий болгоход зориулж өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг сайжруулах нь, Дэлхийн Банк, 2020 он

мэдээлэл болон ажиглалтыг ашиглан (PMT) ООТА-ыг дахин тооцсон ч энэ нь хэрэгжүүлэлтийн алдааг харуулж чадахгүй хэдий ч уг загварын онолын дагуух баттай үнэлгээ юм. Мөн Хүснэгт 10-т бидний хийсэн микро симуляцид үндэслэн нийгмийн халамжид хамрагдалт цар тахлын өмнө болон дараа ямар болсныг харьцуулан харууллаа.

81. ХМХ-ийн зорилтот бүлгийг тодорхойлоход цар тахлын нөлөө ороогүйг дурдах хэрэгтэй бөгөөд ХЭБХ-ийн хувьд цар тахал гарахаас өмнөх үетэй харьцуулахад хамгийн доод бүлгийн хүн амын хамрагдалт муудаж байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь: ХЭБ хөтөлбөрт хүн амын 20 хувь хамрагдаж байхад цар тахлаас өмнө доод бүлгийн хамрагдалт 61.7 хувь байсан бол цар тахлын үед 55.6 хувь болсон. ООТА-ын оноо нь 50% байхад хамрагдалт нь харгалзан 93.8 хувь болон 87.1 хувь байна. Энэхүү бууралт нь төдийлөн их биш бөгөөд бусад шилжүүлэгтэй хамт ашиглахад боломжийн хуваарилалт болж байна.

Хүснэгт 10: ХМХ, ХЭБ хөтөлбөрийн үр шимийг хүртэгчдийн тархалт, цар тахлын өмнө болон дараах үед хүн амын өөр өөр хэсгийг хамруулсанаар

Хүн амын тэнцүү тооны 5 бүлэг	Цар тахлын өмнөх үе					Цар тахлын үе				
	ХМХ	ООТА20	ООТА30	ООТА40	ООТА50	ХМХ	ООТА20	ООТА30	ООТА40	ООТА50
Ядуу	95.6	61.7	77.7	88.5	93.8	95.3	55.6	69.8	80.2	87.1
II	88.6	25.0	42.5	58.1	73.1	89.8	26.6	43.3	58.0	71.3
III	81.6	8.7	19.0	32.1	47.0	82.9	11.7	23.1	36.2	48.9
IV	74.3	3.5	8.0	15.5	25.6	73.1	4.7	10.4	18.6	30.3
Чинээлэг	58.8	0.8	2.6	5.5	10.1	57.9	1.1	3.3	6.7	12.0
Нийт	79.8	20.0	30.0	40.0	50.0	79.8	20.0	30.0	40.0	50.0

82. Өрхүүдийг өөр өөр шалгуураар хамруулахад хэр зэрэг төсөв мөнгө хэрэгтэй болохыг ойлгох нь чухал. Хүүхэд бүр ижил хэмжээний ХМХ, өрхийн гишүүн бүр ижил хэмжээтэй ХЭБ-ийн тэтгэмж авна гэж үзсэн. Хүснэгт 11-т ХМХ-тэй харьцуулахад ХЭБ-ийг ашиглахад төсөөлсөн шилжүүлгээс нилээд их илүү хувь нь хүн амын ядуу хэсэгт очихоор байна.

Хүснэгт 11: Өөр өөр шаардлагыг хангасан иргэдэд олгох боломжит шилжүүлгийн төсвийн тархалт, эдийн засгийн хямралтай 2020 оны 4-9 сарыг хамруулан симуляци хийсний дагуу

Хүн амын тэнцүү тооны 5 бүлэг	Цар тахлын тархалт				
	ХМХ	ООТА20	ООТА30	ООТА40	ООТА50
Ядуу	95.6	61.7	77.7	88.5	87.1
II	88.6	25.0	42.5	58.1	71.3
III	81.6	8.7	19.0	32.1	48.9
IV	74.3	3.5	8.0	15.5	30.3
Чинээлэг	58.8	0.8	2.6	5.5	12.0
Нийт	79.8	20.0	30.0	40.0	50.0

83. Жишээ нь, өөр өөр шилжүүлэг болон тэдгээрийн төсвийн хувилбаруудын ядуурал болон тэгш бус байдалд нөлөөлөх нөлөөг доор харуулж байна. Зөвхөн ихээхэн хэмжээний ХМХ-ийн шилжүүлэг болон харьцангуй бага ХМХ шилжүүлгийг ядуурлын тэтгэмжтэй хослуулсан ӨМНС-г ашиглан ядуу өрхүүдэд чиглэсэн хувилбарыг эдийн засгийн хоёр өөр нөхцөл байдал дахь нөлөөллийг (4-9 сар, 10-12 сарын хугацаанд симуляци хийсэн) үзүүллээ.

84. Эдийн засгийн эерэг нөхцөл байдлын (2020 оны 4-9 сар) үр дүнг ХМХ-ийг 60,000; 50,000 төгрөг болгох, ХМХ-ийн 20,000 төгрөг дээр хүн амын 40 хувийг хамруулан сард 25,000 төгрөгийн ядуурлын тэтгэмж олгох хувилбаруудыг харьцуулан харууллаа. Эхний

шилжүүлэг нь төсвийн хувьд харьцангуй өндөр гарах боловч гурав дахь хувилбар болох ХМХ-ийг ядуурлын тэтгэмжтэй хослуулсанаас илүү үр дүн үзүүлэхээргүй байна. (Хүснэгт 12-ыг харна уу).

Хүснэгт 12: Тэгш бус байдал, ядууралд өөр өөр шилжүүлгийн хувилбаруудын нөлөө, эдийн засгийн хямралтай үед зарцуулах төсөв 2020 оны 4-9 сарыг хамруулан симуляци хийсний дагуу

	ХМХ=60	ХМХ=50	ХМХ=20 + ЯТ40=25
Тэгш бус байдал:			
Жини коэффициент	0.3139	0.3175	0.3105
Ядуу хүн амын эзлэх хувь (өөр өөр ядуурлын шугам)			
Үндэсний	27.8	29.1	28.7
Доод	12.8	14.0	12.8
Дээд	48.6	49.8	50.2
Сарын төсөв (сая төгрөг)	70475	58729	55318

85. 2021 оны эдийн засгийн нөхцөл байдлыг илүү сайн төлөөлөх цар тахлын нөлөөлөл бага байх хувилбаруудыг Хүснэгт 13-т харууллаа. Сард 40,000 төгрөгийн ХМХ болон хүн амын 40 хувьд (ООТА-ын оноонд үндэслэн 5 тэнцүү бүлгийн доод 40 хувьд) сард нэг хүнд 10,000 төгрөг, хүн амын 20 хувьд (ООТА-ын оноонд үндэслэн 5 тэнцүү бүлгийн доод 20 хувьд) сард 15,000 төгрөгийн ядуурлын тэтгэмжийг сарын 20,000 төгрөгийн ХМХ-ийн багцуудыг харьцуулан авч үзсэн.

86. Хэмнэлттэй төсвийн түвшинд сард 30,000 төгрөгийн хүүхдийн мөнгө олгох хувилбарыг сар бүр 20,000 төгрөгийн хүүхдийн мөнгө дээр хүн амын 20 хувийг хамарсан сарын 20,000 төгрөгийн ядуурлын тэтгэмж, эсвэл хүн амын 30 хувийг хамарсан сард 10,000 төгрөгийн ядуурлын тэтгэмж олгох хувилбарыг авч үзсэн.

Хүснэгт 13: Тэгш бус байдал, ядууралд өөр өөр шилжүүлгийн хувилбаруудын нөлөө, эдийн засгийн хямралтай үед зарцуулах төсөв 2020 оны 10-12 сарыг хамруулан симуляци хийсний дагуу

	ХМХ=40	ХМХ=20 + ЯТ40=10 + ЯТ20=15	ХМХ=30	ХМХ=20 + ЯТ20=20	ХМХ=20 + ЯТ30=10
Тэгш бус байдал:					
Жини коэффициент	0.3127	0.3055	0.3163	0.3106	0.3136
Ядуу хүн амын эзлэх хувь (өөр өөр ядуурлын шугам)					
Үндэсний	25.2	24.4	26.8	26.1	26.6
Доод	11.2	9.6	12.3	10.9	11.9
Дээд	45.3	45.7	46.5	46.8	46.9
Сарын төсөв (сая төгрөг)	46983	45761	35237	36210	33040

87. Эдгээр симуляци нь нийгмийг халамжийн төрлүүдийг хослуулан хэрэгжүүлсэнээр өндөр дүнтэй ХМХ хэрэгжүүлэхтэй харьцуулахад бага төсвөөр ойролцоо эсвэл илүү хэмжээгээр ядуурлыг бууруулж болохыг харуулсан жишээ юм. ХМХ-өөс хэмнэсэн мөнгөөр цар тахлын нөлөөнд хүндээр өртсөн зарим салбарын ажиллагчдын мэргэшлийг дээшлүүлэх, тэтгэлэгт сургалтанд хамруулж өөр ажилд шилжихэд нь дэмжлэг үзүүлэхэд зарцуулж болох юм.

6 Дүгнэлт, дараагийн алхам

88. Энэхүү тайлангийн дүгнэлт нь бидний дэвшүүлсэн таамаглалд үндэслэсэн бөгөөд тэдгээрийн үнэн зөв эсэх нь тодорхойгүй байгааг дурдах хэрэгтэй ч уг судалгаа нь Засгийн Газрын хариу үйлдэл үр дүнтэй байгааг харуулж байна. Ажилгүйдэлд өртөх нь нь төсөөлснөөс их байвал хямралын үеийн эдийн засагт нөлөөлсөн нөлөөллийн талаарх төсөөлөл доогуур тооцоологдсон байж болзошгүй. Ялангуяа нийгмийн хамгааллын бодлого хүн амын нэлээдгүй хувийг хамарч, Засгийн газрын шилжүүлгийн томоохон хэсгийг эзэлж байгаа юм. ХМХ, нийгмийн халамжийн тэтгэвэр болон хүнсний эрхийн бичиг хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн дахин хуваарилалтын шилжүүлгүүд юм.

89. Тиймээс Засгийн газрын богино хугацааны хариу үйлдэл нь ихээхэн үр дүнтэй, ядуурлыг бууруулахад чиглэсэн, дэлхийн бусад олон оронд тохиолдож байгаа цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөллөөс сэргийлж чадсан ихээхэн үр дүнтэй болсон гэж дүгнэж байна. Гэхдээ бодит амьдрал дээр бодлого хэр зэрэг сайн хэрэгжсэн, зорилтот өрхүүдэд зөв хуваарилагдаж чадсан эсэхээс хамаарах бөгөөд энэ асуудлыг энэхүү судалгаанаас гадна НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр явагдаж байгаа судалгаагаар мөн судлан авч үзнэ.

90. Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн 2-р үе шатыг 10 дугаар сараас эхлүүлэх бөгөөд аж ахуйн нэгж болон ажиллагчдад чиглэсэн дэмжлэг буурч, ядуучуудад чиглэсэн бодлогыг хэвээр үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.

91. Дараагийн чухал алхам бол 2021 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох явдал юм. Цар тахал гарахаас өмнө, 2012 оноос сард нэг хүүхдэд 20,000 төгрөг олгож байсан бөгөөд үүнийг 2020 оны үнээр үнэлж үзвэл 35,000 төгрөг орчим болж байна. Нэг хүүхдэд одоогоор олгож байгаа 100,000 төгрөгийг хэвээр үлдээхэд санхүүгийн бэрхшээлтэй учирч болох тул эдийн засгийн сэргэлтийг харгалзан аажмаар бууруулах хэрэгтэй бөгөөд хамгийн доод түвшиндээ 40 орчим мянган төгрөг байлгахыг харгалзан үзэх нь зүйтэй. Энэ тохиолдолд симуляци ирээдүйн өртгийг тодорхойлох гол хэрэгсэл болох юм. Түүнчлэн ХМХ-ийн нэмэгдлийг ӨМНС болон зах зээлийн идэвхтэй бодлогыг ашиглан зорилтот бүлэгт илүү чиглэсэн тэтгэмжтэй хослуулан ашиглаж болно.

92. 2021 онд эдийн засгийн ямар салбар уналтад орох магадлалтай байгааг тодорхойлох, уг салбараас хамааралтай өрхүүдэд чиглэсэн тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ихээхэн чухал юм. Өөр өөр шилжүүлгийн хувилбаруудын симуляци нь хэд хэдэн төрлийн тэтгэмжийг хослуулан олгох боломжит хувилбаруудын жишээ бөгөөд үүнийг 2021 онд хэрэгжүүлэх бодлогын хариу арга хэмжээг тодорхойлох чиглэл болгож ашиглах боломжтой.

93. Хэдийгээр инфляцийн түвшинг барьж байгаа ч эдийн засаг дахь их хэмжээний мөнгөний нийлүүлэлт, шилжүүлгийн үед ялангуяа ядуучуудын амьжиргаанд хүндээр тусч болох өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг хянаж байх нь зүйтэй.

Ном зүй

НҮБХХ, 2020. 'Монгол улсын эмзэг бүлэгт үзүүлэх КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ', Улаанбаатар, Монгол Улс <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/rapid-socio-economic-impact-assessment-of-covid-19-.html>.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, 2018. Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгаа, Улаанбаатар, Монгол Улс

Үндэсний Статистикийн Хороо, 2020: Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус (COVID-19)-ээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөлөл https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Impact_of_COVID-19_on_Business_Activities.pdf&ln=En.

WB (2020): COVID-19 Crisis through a Migration Lens; Migration and Development Brief 32 <http://documents1.worldbank.org/curated/en/989721587512418006/pdf/COVID-19-Crisis-Through-a-Migration-Lens.pdf>


Uochi, Ikuko (2020): Mongolia Poverty Update. Washington, D.C.: World Bank Group. <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/532121589213323583/mongolia-poverty-update-2018>

Дэлхийн банк, 2020. Монгол Улсын өрхүүдийн КОВИД-19-ийн нөлөөллийг хянах нь. Монгол Улсын КОВИД-19 өрхийн утсанд суурилсан судалгааны (нэгдүгээр үе шат) үр дүн. Дэлхийн Банк ба Үндэсний Статистикийн Хороо (<https://www.worldbank.org/en/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>)

Хавсралт А: Статистикийн нарийвчилсан хэмжүүрүүд


Үндсэн хэсэгт цочролын өмнөх болон дараах хэрэглээ, орлогын дундаж болон бүлгийн хэмжүүрүүдийн өөрчлөлтүүдийг дурдсан бөгөөд Зураг 6-д судалгаанд хамрагдсан бүхий л өрхүүдийг цэгээр тэмдэглэн цочролын өмнөх болон дараах хэрэглээний хамаарлыг харууллаа. График нь хэрэглээ өөрчлөгдөхгүй (бодит нөхцөлөөр) олон өрхүүд байгаа, эсвэл коронавирусаас шалтгаалан хэрэглээ нь буурсан (шугамын доорх бүх цэг) мөн зарим хүмүүсийн хувьд нэмэгдсэн (шугамаас дээрх цэгүүд) учраас бараг 45 хэмийн өнцөгтэй байна.

Зураг 6: Цочролын өмнө болон дараах үеийн хэрэглээний өөрчлөлт – 2020 оны 4-9 сар




Дээрх графикт цочролын дараах дундаж хэрэглээг centile тус бүрээр тооцож харуулсан. Зураг 7-д цочролын өмнөх болон дараах үеийн хэрэглээ нь өөрчлөлтгүй байгаа ба цэг болгон нь centile тус бүрээр цочролын дараах дундаж хэрэглээг харуулж байна.

Зураг 7: Цочролын өмнө болон дараах үеийн хэрэглээний өөрчлөлт – sentile тус бүрийн дундаж – 2020 оны 4-9 сар



Зураг 8 нь Зураг 4-тэй төстэй хэдий ч эрэмбэлэлт нь цочролын дараах бус суурь үеийн тархалтанд тулгуурласан гэдгээрээ ялгаатай.

Зураг 8: Суурь үетэй харьцуулсан нэг хүнд ногдох хэрэглээний зардлын өөрчлөлтийн хувь (цочролын дараах хэрэглээгээр эрэмбэлсэн) –2020 оны 4-9 сар



Хүснэгт 14: Ядуурлын дүр төрх, хувилбар тооцоо – 2020 оны 4-9 сар

	Суурь үе			Цар тахлын нөлөө			Бууруулах арга хэмжээ		
	Улсын дундаж	Доод	Дээд	Улсын дундаж	Доод	Дээд	Улсын дундаж	Доод	Дээд
Улсын дундаж	28.4	13.9	46.5	36.7	20.7	55.1	17.6	6.4	37.5
Байршлаар									
Хот	27.2	13.9	43.8	35.1	20.2	52.2	17.1	7.0	35.5
Хөдөө	30.8	14.0	51.6	39.9	21.5	60.6	18.6	5.3	41.5
Газар зүйн бүсээр									
Баруун	31.8	15.3	53.4	42.3	23.6	63.3	19.5	7.0	42.3
Уулархаг	30.8	14.1	51.8	40.0	21.7	60.3	18.7	5.8	41.7
Төв	26.1	12.6	44.0	34.2	18.8	53.2	16.1	5.6	35.6
Зүүн	37.4	20.3	55.3	43.2	26.4	61.5	24.9	6.6	46.8
Улаанбаатар	25.9	12.9	41.8	33.7	19.1	50.2	16.1	6.8	33.8
18 хүртэлх насны хүүхдийн тоогоор (<=17)									
хүүхэдгүй	7.6	2.5	21.0	12.3	4.9	27.0	8.2	3.2	20.9
нэг	17.0	6.5	35.1	24.9	11.7	45.4	12.6	4.4	29.9
хоёр	28.5	12.3	49.4	38.6	20.2	59.2	16.4	5.7	37.3
гурав	43.4	21.5	63.4	53.7	31.2	72.7	23.5	8.2	49.2
дөрөв ба түүнээс дээш	62.4	39.9	78.6	70.1	49.5	84.3	37.5	15.0	63.2
Тэтгэвэр авагчийн тоогоор									
байхгүй	29.9	14.7	48.1	39.5	22.7	57.7	18.1	6.7	38.0
нэг	26.4	13.6	44.5	31.7	17.3	50.5	18.2	6.7	38.5
хоёр ба түүнээс дээш	17.7	6.4	35.2	20.6	7.9	38.6	12.0	3.7	30.7
ХБИ-ийн тоогоор									
байхгүй	27.4	13.2	45.1	36.0	20.2	54.1	17.1	6.1	36.6
нэг	33.0	17.2	53.5	40.0	22.5	59.5	19.7	8.2	41.9
хоёр ба түүнээс дээш	46.3	25.8	65.2	50.6	31.8	69.2	27.5	10.8	54.9
Өрхийн төрөл									
Ганц бие, тэтгэврийн насны бус	1.6	0.4	6.8	6.5	3.1	14.4	4.8	2.6	9.3
Ганц бие, тэтгэврийн насны	2.4	0.7	11.1	2.8	0.7	12.2	2.1	0.7	11.4
Хүүхэдгүй хос, тэтгэврийн насны бус	4.4	2.1	16.4	11.1	5.5	25.0	7.1	3.4	17.9
Хүүхэдгүй хос, тэтгэврийн насны	3.2	0.6	15.2	5.0	1.1	18.1	3.9	0.9	16.5
1 хүүхэдтэй хос	14.0	4.6	30.6	23.4	10.7	42.7	10.9	4.0	26.8
2 хүүхэдтэй хос	25.2	10.2	46.5	36.5	18.7	57.3	14.9	5.1	34.6
3 хүүхэдтэй хос	37.6	16.4	58.2	48.8	27.0	68.7	19.1	6.3	43.8
4 ба түүнээс дээш хүүхэдтэй хос	57.1	33.3	74.3	65.8	44.3	80.6	31.9	12.2	57.9
Хүүхэдтэй ганц бие эцэг/эх	37.3	21.6	57.2	44.4	28.0	63.2	18.1	6.1	38.5
Гурван үе	40.8	22.5	60.6	47.9	28.7	67.9	27.0	10.3	50.9
Бусад бүх насанд хүрэгчид	11.2	3.8	27.2	17.0	6.8	34.0	11.0	4.2	26.0
Хүүхэдтэй бусад өрхүүд	36.4	19.7	51.5	43.3	25.8	59.7	21.7	8.6	44.4

Хүснэгт 15: Ядуурлын дүр төрх, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдэл, НДШ/ХХОАТ-ын чөлөөлөлттэй үед – 2020 оны 4-9 сар

	Цар тахлын нөлөө			Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлсэн			НДШ, ХХОАТ-ын чөлөөлөлт		
	Улсын дундаж	Доод	Дээд	Улсын дундаж	Доод	Дээд	Улсын дундаж	Доод	Дээд
Улсын дундаж	36.7	20.6	55.0	24.8	10.6	46.2	30.5	16.3	48.8
Байршлаар									
Хот	35.1	20.2	52.2	24.0	11.0	43.9	28.4	15.7	45.1
Хөдөө	39.9	21.5	60.6	26.5	9.8	50.6	34.6	17.5	56.0
Газар зүйн бүсээр									
Баруун	42.3	23.6	63.3	26.7	11.5	51.9	37.6	19.9	59.0
Уулархаг	40.0	21.7	60.3	27.0	10.2	51.0	34.2	17.1	55.1
Төв	34.1	18.9	53.3	22.6	9.1	43.7	28.4	14.9	47.2
Зүүн	43.2	26.4	61.5	31.9	12.6	52.8	38.6	22.0	57.6
Улаанбаатар	33.7	19.1	50.2	23.1	10.6	42.5	26.4	14.5	42.6
18 хүртэлх насны хүүхдийн тоогоор (<=17)									
хүүхэдгүй	12.3	4.9	27.0	12.3	4.9	27.0	9.8	3.8	22.8
нэг	24.9	11.7	45.4	18.6	7.6	38.6	19.2	8.8	38.4
хоёр	38.6	20.2	59.2	24.9	9.5	47.0	30.8	15.1	51.5
гурав	53.8	31.2	72.7	32.4	13.8	59.0	45.1	24.2	65.7
дөрөв ба түүнээс дээш	70.0	49.4	84.3	46.4	23.6	71.6	64.0	42.8	80.5
Тэтгэвэр авагчийн тоогоор									
байхгүй	39.4	22.7	57.7	25.9	11.0	47.5	32.6	17.7	50.7
нэг	31.8	17.2	50.5	24.1	10.8	45.3	26.8	14.4	46.2
хоёр ба түүнээс дээш	20.6	7.8	38.6	16.3	5.4	34.7	17.7	6.9	35.7
ХБИ-ийн тоогоор									
байхгүй	35.9	20.1	54.1	23.8	10.0	45.0	29.6	15.6	47.6
нэг	40.1	22.5	59.5	29.2	13.4	52.0	34.1	18.8	55.1
хоёр ба түүнээс дээш	51.0	31.7	69.4	42.7	20.1	65.5	47.7	29.8	66.3
Өрхийн төрөл									
Ганц бие, тэтгэврийн насны бус	6.4	3.1	14.4	6.4	3.1	14.4	5.2	2.7	11.0
Ганц бие, тэтгэврийн насны	2.8	0.7	12.2	2.8	0.7	12.2	2.8	0.7	12.1
Хүүхэдгүй хос, тэтгэврийн насны бус	11.1	5.5	25.0	11.1	5.5	25.0	8.5	4.0	19.7
Хүүхэдгүй хос, тэтгэврийн насны	5.0	1.1	18.1	5.0	1.1	18.1	4.3	1.1	17.5
1 хүүхэдтэй хос	23.3	10.7	42.7	17.2	6.8	36.3	17.3	7.8	34.9
2 хүүхэдтэй хос	36.5	18.7	57.3	22.7	8.2	44.4	28.8	13.8	49.0
3 хүүхэдтэй хос	48.9	27.0	68.8	27.6	10.7	53.6	40.0	20.4	60.8
4 ба түүнээс дээш хүүхэдтэй хос	65.7	44.3	80.7	41.0	19.7	66.1	59.4	37.5	76.5
Хүүхэдтэй ганц бие эцэг/эх	44.3	28.1	63.2	24.3	10.0	48.9	38.1	23.6	57.8
Гурван үе	48.0	28.5	67.9	35.9	16.8	59.8	40.6	23.4	62.0
Бусад бүх насанд хүрэгчид	16.9	6.8	34.1	16.9	6.8	34.1	13.4	5.1	28.4
Хүүхэдтэй бусад өрхүүд	43.3	25.6	59.6	30.2	14.6	51.4	38.1	19.8	55.1